



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2021 • № 58



Б.ЛХАГВАСҮРЭН:
ЭДИЙН ЗАСГИЙН
ИДЭВХЖЛЭЭС
ХАМААРЧ МӨНГӨНИЙ
БОДЛОГЫН
ТОХИРУУЛГА ХИЙНЭ

МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСГИЙГ
ТОГТВОРЖУУЛАХ
БОДЛОГО,
ЗАГВАРЧЛАЛЫН
АСУУДАЛ

Тайлбар: Очироор огтлогч буюу Дорж Зодва хөлгөн судар



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

БОДЛОГЫН ХҮҮГ ХЭВЭЭР ХАДГАЛАХ, САНХҮҮЖИЛТИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Дугаар: 2021/03

Огноо: 2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны төлөв байдлыг харгалзан:

1. Бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах;
2. Урт хугацаат репо санхүүжилтийн хэмжээг 2021 оны 4 дүгээр улиралд 100 хүртэлх тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх шийдвэр гаргалаа.

Жилийн инфляц 2021 оны 8 дугаар сард улсын хэмжээнд 8.9 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 9.1 хувьд хүрч өслөө. Инфляц эдийн засгийн сэргэлтийн нөлөөгөөр нэмэгдэж байгаа боловч дийлэнх хэсгийг нь суурь үеийн нөлөө, нэг удаагийн шинжтэй нийлүүлэлтийн хүчин зүйлс тайлбарлаж байна. Эдгээр хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляц өсөх хэдий ч 2022 оны сүүлийн хагаст Төв банкны зорилтын орчимд тогтворжих хүлээлт хэвээр байна. Гэвч дэлхийн эдийн засгийн сэргэлт, олон улсын нийлүүлэлтийн сүлжээ, логиستيкийн сааталтай холбоотойгоор гадаад инфляц болон дэлхийн зах зээл дээрх хүнс, сатахууны үнэ хүлээлтээс давж өсөх, дотоод зах зээл дээр нийлүүлэлтийн шалтгаанаар инфляцын төлөв нэмэгдэх эрсдэлтэй байна.

Дэлхийн эдийн засгийн өсөлт нэмэгдэж, ихэнх экспортын бүтээгдэхүүний үнэ өндөр түвшинд хадгалагдаж байгаа боловч үүнээс бий болж буй эерэг нөлөө хүлээлтээс бага байлаа. Засгийн газар болон Төв банкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийг сэргээх бодлогын арга хэмжээ эдийн засгийн идэвхжилд эерэг нөлөөтэй байгаа хэдий ч нүүрсний экспорт, үйлдвэрлэл улмаар тээврийн салбар, импортын саатал болон өмнөх хөл хорионы нөлөөгөөр барилга, боловсруулалт, үйлчилгээний салбарын идэвхжил хүлээлтээс бага байсан нь эдийн засгийн өсөлт өмнөх улирлаас саарахад голлон нөлөөлөв. Дэлхий дахинд вирусийн шинэ хувилбарын тархалт үргэлжилж, вакцинжуулалтын үр нөлөөг бууруулж, болгоомжлолыг нэмэгдүүлж байгаа нь цар тахлаас үүдэлтэй тодорхой бус байдлыг эдийн засгийн гадаад, дотоод орчинд үүсгэж байна.

Эдийн засагт цар тахлын учруулж буй хүндрэлийн үед Төв банкны зүгээс хэрэгжүүлж буй мөнгөний болон макро зохистой бодлого, санхүүгийн хөнгөлөлтийн арга хэмжээнүүд нь эдийн засгийн сэргэлт, санхүүгийн салбарын тогтвортой байдалд дэмжлэг болж байна.

Мөнгөний бодлогын одоогийн төлөв нь инфляцыг тогтворжуулах, эдийн засгийг сэргээх зорилттой нийцтэй байгаа бөгөөд цаашид эдийн засгийн сэргэлт тогтворжиж, инфляц түр зуурын бус шинжтэйгээр зорилтоос давах эрсдэл үүсвэл шаардлагатай бодлогын тохируулга хийх болно.

Мөнгөний бодлогын хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.


МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО



04

ОНЦЛОХ МЭДЭЭ

ТӨВ БАНКУУДЫН
ЧАДАВХЫГ
БЭХЖҮҮЛЭХ ОЛОН
УЛСЫН ХӨТӨЛБӨРТ
ХАМРАГДАВ



12

БАЙР СУУРЬ

“ТӨРӨӨС МӨНГӨНИЙ
БОДЛОГЫН ТАЛААР
2022 ОНД БАРИМТЛАХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-
ИЙН ТӨСЛИЙГ
ХЭЛЭЛЦҮҮЛЭХ
ХҮРЭЭНД ЭДИЙН
ЗАСАГЧИД БОЛОН
МЭРГЭЖЛИЙН
БАЙГУУЛЛАГУУДЫН
ТӨЛӨӨЛӨЛ БАЙР
СУУРИА ИЛЭРХИЙЛЛЭЭ



09

ЯРИЛЦАГА

Б.ЛХАГВАСҮРЭН:
ЭДИЙН ЗАСГИЙН
ИДЭВХЖЛЭЭС
ХАМААРЧ МӨНГӨНИЙ
БОДЛОГЫН
ТОХИРУУЛГА ХИЙНЭ



18

АСУУЛТ, ХАРИУЛТ

МӨНГӨНИЙ
БОДЛОГЫН
ХЭВЛЭЛИЙН БАГА
ХУРАЛ ТАНИЛЦУУЛАХ
ХЭВЛЭЛИЙН БАГА
ХУРАЛ
2021.09.16



25

МОНГОЛБАНК ЮУ
ХИЙДЭГ ВЭ?

МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСГИЙГ
ТОГТВОРЖУУЛАХ
БОДЛОГО,
ЗАГВАРЧЛАЛЫН
АСУУДАЛ



35

ДЭЛХИЙН ЭДИЙН
ЗАСАГ

2021 ОНД
БОДЛОГЫН ХҮҮГЭЭ
ӨСГӨСӨН ТӨВ
БАНКУУД



41

СУДАЛГАА

КОВИД-19
ХАЛДВАРЫН ЦАР
ТАХЛЫН ҮЕИЙН ОЛОН
УЛС ДАХЬ ТӨСВИЙН
БОДЛОГО



46

САНХҮҮГИЙН
БОЛОВСРОЛ

МОНГОЛ УЛСЫН
БИЧИЛ, ЖИЖИГ,
ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ,
ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭГЧДИЙН
САНХҮҮГИЙН
МЭДЛЭГИЙГ
ДЭЭШЛҮҮЛЭХ
ДУНД ХУГАЦААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨ

ТӨВ БАНКУУДЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ОЛОН УЛСЫН ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАВ

2021.08.06



Швейцарын Холбооны Улсын Эдийн Засгийн Газар (SECO)-аас хэрэгжүүлдэг Төв банкуудын чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрт Монголбанк хамрагдах санамж бичгийг талууд байгууллаа. Санамж бичигт Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Швейцарын Хамтын ажиллагааны газар, Консулын хэлтсийн дарга Стефани Бурри нар гарын үсэг зурав. Энэхүү хөтөлбөрт хамрагдсанаар Монголбанкны мөнгөний бодлогын шинжилгээ, макро-эдийн засгийн судалгаа, статистик, бодлого үйл ажиллагааны чадавхыг нэмэгдүүлж, олон улсын жишигт ойртуулахад дөхөм болох юм. Тус хөтөлбөр нь 2013 оноос хөгжиж буй улс орнуудын Төв банкуудын аналитик болон техник экспертизийг хөгжүүлэхэд зорьжээ. Одоогоор Албани, Азербайжан, Босни ба Херцеговина, Колумб, Морокко, Перу, Тунис, Украин зэрэг улс орон энэхүү хөтөлбөрт амжилттай хамрагдан 54 удаагийн судалгааны ажлыг хийжээ.

МОНГОЛБАНКНААС ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДАД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЛОО

2021.08.25



Монголбанкнаас Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан финтек компаниудад төлбөрийн үйлчилгээний зөвшөөрлийн гэрчилгээг гардуулах үйл ажиллагаа боллоо. Энэ үеэр Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Г. Энхтайван зөвшөөрөл гардаж буй аж ахуйн нэгжүүдэд хандаж, финтек компаниуд нь хууль тогтоомжийг баримтлан, хэрэглэгчийн эрх ашигт нийцсэн төлбөрийн үйлчилгээг нэвтрүүлэн, нууцлал аюулгүй байдлыг хангаж түргэн шуурхай, найдвартай ажиллах шаардлагатай тухай онцлов. Цахим мөнгө гаргах зөвшөөрлийг “Эм Пи Эс Си” ББСБ ХХК, “Инвескор хэтэвч” ББСБ ХХК-д, төлбөрийн карт гаргах, хүлээн авах зөвшөөрлийг “Ашид капитал” ББСБ ХХК-д төлбөрийн картын процессорын зөвшөөрлийг “М” ХХК, “Гэрэгэ системс” ХХК-д тус олгов.

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ БОЛЛОО

2021.09.07



Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний зөвлөл хуралдаж, “Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр”, мөн “Монгол Улсын 2020 оны Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний явц, үр дүн”-гийн талаар тус хэлэлцлээ. Түүнчлэн виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх, ФАТФ-ын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт тайлагнах, Монгол Улсын 2021 оны явцын тайлан, цаашид шийдвэрлэх асуудлуудыг хэлэлцэв. Энэ хүрээнд Үндэсний зөвлөлийн гишүүн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг байгуулах, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах ажлын төлөвлөгөөг батлахаар шийдвэрлэлээ. Хуралдааныг Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар удирдаж, зөвлөлийн гишүүн 16 байгууллагын 31 төлөөлөл оролцов.

ЦАХИМ ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД 300 ДАХИН ӨСЧЭЭ

2021.09.08



Цахим залилан луйврын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Ятгах тусам нягтал-2021” аяны хүрээнд “Цахим орчин дахь залилах гэмт хэрэг” сэдэвт хэлэлцүүлэг боллоо. Хэлэлцүүлэгт Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Цагдаагийн Ерөнхий Газрын Тэргүүн Дэд дарга, цагдаагийн хурандаа Ц.Ням-Очир, Монголын банкны холбооны Дэд ерөнхийлөгч Р.Мөнхтуяа, Мөрдөн байцаах албаны дарга, цагдаагийн хурандаа Б.Батсуурь болон бусад албаны хүмүүс танхимаар болон цахимаар оролцов. Хэлэлцүүлгийн үеэр тавигдсан илтгэлүүдэд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр улс орнуудын цахим орчин дахь хэрэглээ нэмэгдэхийн хэрээр “залилах” гэмт хэргийн хохирлын хэмжээ өссөн нэмэгдэж байгааг онцолж байв. Тухайлбал, Холбооны мөрдөх товчооны мэдээллээр цар тахлын улмаас цахим халдлага 300 хувиар өссөн байна. Тэгвэл манай орны хувьд нөхцөл байдал ижил түвшинд хүрсэн бөгөөд 2021 оны эхний 6 сарын байдлаар цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 24.7 хувийг зөвхөн залилах гэмт хэрэг эзэлж байна. 2020 оны эцсийн байдлаар залилах гэмт хэргийн тохиолдлын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.4 дахин буурсан хэдий ч хохирлын хэмжээ 67.2 тэрбум төгрөгт хүрчээ.

"УУЛ УУРХАЙН БУС ЭКСПОРТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ АСУУДЛУУД" ЦАХИМ УУЛЗАЛТААР ЭДИЙН ЗАСГИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ ОНЦЛОВ

2021.09.08



Уг уулзалтыг Монголбанк, МҮХАҮТ хамтран цахим хэлбэрээр зохион байгуулав. Цахим уулзалтад 100 гаруй бизнес эрхлэгчид болон судлаачид оролцлоо. Энэ үеэр уул уурхайн бус салбарын экспортын хөгжил нь Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд чухал ач холбогдолтой болохыг тэмдэглэж, экспортын үйл ажиллагаа эрхлэгчдэд тулгарч буй санхүүгийн хүндрэлүүд, кластер хөгжлийн боломж, экспортын бүтээгдэхүүнд олон улсын стандартыг нутагшуулах зэрэг олон асуудлыг хөндөв. Энэ үеэр тавигдсан илтгэлүүдийг бүрэн эхээр нь www.mongolbank.mn цахим хуудсанд байршуулжээ.

БАНКНЫ АЖИЛТНУУДЫГ ХАРИЛЦАГЧИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНД СУРГАЖ, МЭРГЭШҮҮЛЭВ

2021.09.15



Монголбанк, Монголын Банкны Холбоо, ХБНГУ-ын Шпаркассэ банкны сан хамтран “Монгол Улсад банкны ажилтныг мэргэшүүлэх-онол, практик хосолсон жилийн сургалтыг 2017 оноос хэрэгжүүлж байна. Энэ хугацаанд 11 банкны нийт 185 ажилтан хамрагдсан төдийгүй 34 сургагч багш бэлтгэгджээ. 2020 оны хувьд 30 мэргэжилтэн сурч төгссөн бөгөөд тэдгээрт батламж гардуулах ёслолын ажиллагаанд Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ё.Розенберг, Монголын Банкны Холбооны гүйцэтгэх захирал, Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Амар, ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сангийн суурин төлөөлөгч Маркус Лох нар оролцов. Мөн тус хамтын ажиллагааны хүрээнд ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны хамтарсан санхүүжилтээр Монгол Улсад банк, санхүүгийн салбарын ажилтнуудыг чадваржуулах мэргэжлийн “Шинэ институт” байгуулах, МБХ-ны дэргэдэх “Банк санхүүгийн академи”-ийг шинэчлэх төслийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байна.

МБЗ-ийн гишүүдэд "ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2022 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ"-ийн ТӨСЛИЙГ ТАНИЛЦУУЛАВ

2021.09.17



Монголбанк Монголын бизнесийн зөвлөлийн ээлжит уулзалтад оролцож "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэл"-ийн төслийг танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлэв. Уулзалтын эхэнд Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван мэдээлэл хийж, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа дээрх төслийн талаар илтгэл тавьж, хэлэлцүүлээ.

Ирэх онд Төв банк хуулиар ногдсон үндсэн зорилтоос гадна цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийг даван туулах, сэргэлтийг дэмжих, банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн хүртээмжийг сайжруулахад шаардлагатай бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэлхий нийтийн уриалгад нэгдэх, уул, уурхайн бус салбарын экспортын хөгжлийг эрчимжүүлэх, дижитал шилжилттэй уялдуулан их тоон өгөгдлийг бүрдүүлэх зэрэг шинэлэг зорилтыг дэвшүүлээд байна.

Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн САНХҮҮГИЙН МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИНЭ

2021.09.17



Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл болон "Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгч, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг баталлаа. Үүний дагуу санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хувийн болон бизнесийн санхүүгээ зөв удирдахад дэмжлэг болох сургалт, үйл ажиллагааг 2 үе шаттай зохион байгуулах юм. Ингэснээр бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны давхардлыг арилгаж, харилцан уялдааг хангах, үр дүнг нэмэгдүүлэх замаар эдийн засаг болон санхүүгийн салбарын тогтвортой байдал, хөгжилд хувь нэмэр оруулахаар зорьжээ.



ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2022 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙГ УИХ-Д ӨРГӨН БАРИВ

ОГНОО: 2021/09/27

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэхээр Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн өнөөдөр /2021 оны 9 дүгээр сарын 27/ УИХ-ын дарга Г.Занданшатарт өргөн барилаа.

Ирэх жилд баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэл нь нийгмийн эрүүл мэндийн хямрал бүрэн илааршаагүй, эдийн засаг, санхүүгийн хүндрэлээс сэргэж буй үед боловсруулагдаж байна. Иймд эдийн засгийн сэргэлтийг дэмжих, дунд хугацааны тогтвортой байдлыг хангах, түүнтэй уялдуулсан бүтцийн өөрчлөлтийн бодлогыг төрийн эрх бүхий байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх зорилтуудыг дэвшүүлж байна.

- Эдийн засгийн өсөлт: Монгол Улсын Засгийн газар, Төв банкнаас цар тахлын сөрөг нөлөөг бууруулах, эдийн засгийн сэргэлтийг дэмжих зорилгоор багц бодлого, зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь ирэх жилийн эдийн засгийн өсөлтийг дэмжинэ. Ирэх онд

эдийн засаг 5.9 хувиар өсөхөд уул уурхайн бус салбарын сэргэлт голлох нөлөөг үзүүлнэ. Түүнчлэн гадаадын шууд хөрөнгө оруулалт, экспортын орлого дотоод эрэлтийг дэмжинэ.

- Инфляц: Эдийн засгийн сэргэлт, гадаад, дотоод нийлүүлэлтийн хүчин зүйлс инфляцад нөлөөлж байгаа хэдий ч ирэх онд Төв банкны зорилтын орчимд тогтворжих хүлээлт хэвээр байна. Ирэх оны 4 дүгээр улирлын дундаж инфляц 6.9 хувь байх хүлээлттэй байгаа бөгөөд цаашид инфляцыг 6%-ийн голчтой +/-2 хувийн интервалтай түвшинд тогтворжуулах дунд хугацааг харсан мөнгөний бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- Зээлийн өсөлт: Банкуудын болгоомжлол үргэлжилсэн хэвээр байгаа хэдий ч ажлын байрыг дэмжих зээлийн төлөвлөгөө амжилттай хэрэгжиж зээлийн хэмжээ өнгөрсөн оноос 14 хувиар өсөөд

байна. Ирэх жилийн хувьд эдийн засгийн сэргэлтийг дэмжихэд шаардлагатай зээлийн өсөлтийг 14-15 орчим хувьд хүлээж байна. Цаашид дунд хугацааны тогтвортой байдлыг хангах зээлийн өсөлтийн түвшинг 15-20 хувьд тогтворжуулна.

- Төлбөрийн тэнцэл: Гадаад, дотоод эдийн засгийн сэргэлттэй холбоотойгоор нийт төлбөрийн тэнцэл 2022 онд 200 гаруй сая ам.долларын ашигтай байх төлөвтэй байна. Дотоод эдийн засгийн сэргэлт нь импортыг нэмэгдүүлж байгаа ч дэлхийн эдийн засгийн сэргэлт Монгол Улсын экспортын үнэд таатай нөлөө үзүүлж байна. Түүнчлэн, олон улсын санхүүгийн байгууллагууд, донорууд, бизнесийн түншүүдийн санхүүгийн дэмжлэг валютын урсгалыг дэмжих төлөвтэй байна.

Эдийн засгийн сэргэлт үргэлжилж байгаа хэдий ч дараах хэд хэдэн асуудалд ойрын хугацаанд голлон анхаарал хандуулах шаардлагатай байна. Тухайлбал,

- Цар тахлын нөхцөл байдал төсөөллийн тодорхой бус байдлын гол эх сурвалж байна.
- Эдийн засгийн сэргэлт жигд бус, хүртээмжтэй бус байна. Өрхийн хэрэглээ сүүлийн 3 улирал агшсан, үйлчилгээний салбарын агшилт үргэлжилж байна.
- Уул уурхайн салбарын хувьд нүүрсний экспортод үүссэн доголдол нь уул уурхайн салбарын өсөлт, түүнийг дагасан холбогдох салбаруудын өсөлтөд сөргөөр нөлөөлж, валютын урсгалыг нэмэгдүүлэх боломжийг алдагдуулсаар байна.
- Түүнчлэн, тээвэр логистикийн доголдол нь бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг нэмэгдүүлж, сэргэлтийг удаашруулж байна.

- Инфляц 8 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 8.9%-д хүрч нэмэгдсэн хэдий ч гадаад, дотоод нийлүүлэлтийн хүчин зүйлс дийлэнх хувийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, инфляцын хувьд 7-8 дугаар сар нь импортын барааны томоохон нөлөөтэй сарууд болж өнгөрлөө.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлд төрийн эрх бүхий бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр дараах асуудлуудыг бодлогын зорилт болгон тусгалаа.

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах 2022 онд баримтлах үндсэн чиглэл нь ковидын хүндрэлээс гаргах ногоон-хүртээмжтэй сэргэлтийг дэмжсэн бүтцийн өөрчлөлтийн эхлэлийг тавихаар зорьж байна. Эдгээр асуудлууд нь цар тахлын дараах сэргэлтийн бодлоготой уялдаж, дэлхий нийтээр анхаарал хандуулж байгааг онцлох нь зүйтэй.

Дунд хугацааны тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн уул уурхайн бус экспортын бизнесийн орчныг сайжруулах, зээлийн хүүг бууруулахад чиглэсэн хууль эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлэх, ипотекийн зээлийн тогтолцоог сайжруулах чиглэлээр бусад бодлого боловсруулагч, зохицуулагч байгууллагуудтай хамтран ажиллахаар төлөвлөж байна. Түүнчлэн, ФАТФ-ын 2023 оны харилцан үнэлгээний бэлтгэл ажлыг хангах, сайжруулах арга хэмжээнүүдийг эрчимжүүлэх чиглэлийн ажлуудыг зорилт болгож байна.

Түүнчлэн, макро эдийн засгийн бодлогын хувьд инфляцыг тогтворжуулах, банкны системийн шинэчлэлийг гүнзгийрүүлж, тогтвортой байдлыг хангах, төлбөрийн системийн найдвартай байдлыг хангах, хөгжлийг дэмжихэд чиглэсэн Монголбанкны мөнгөний бодлого, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого үйл ажиллагааг бие даан хэрэгжүүлэхээр төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлд тусгалаа.

Б.ЛХАГВАСҮРЭН: ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХЖЛЭЭС ХАМААРЧ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТОХИРУУЛГА ХИЙНЭ



Монголбанк Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг УИХ-д өргөн бариад байна. Төв банкнаас ирэх онд хэрэгжүүлэх бодлогын талаар Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнтэй ярилцлаа.

Жил бүрийн намар Монголбанк ирэх оны мөнгөний бодлогын үндсэн чиглэлээ УИХ-аар батлуулдаг. Инфляцын түвшин 8.9%-д хүрч Төв банкны 6+/-2% интервалтай зорилтыг даваад байгаа энэ үед мөнгөний бодлогын зорилтоо хэрхэн тодорхойлсон нь анхаарал татаж байна?

-Монголбанкнаас ирэх онд хэрэгжүүлэх бодлого үндсэндээ цар тахлын хүндрэлийг даван туулах, сорилт хүндрэлийн үед санхүүгийн зах зээлийн эрх зүйн орчин болон дэд бүтцийг тасралтгүй хөгжүүлэх, түүнчлэн тэгш бус байдал, цаг уурын өөрчлөлт зэрэг эдийн засгийн урт хугацааны томоохон асуудлуудад анхаарал хандуулснаараа онцлог болох юм.

Инфляцын хувьд Төв банкны

зорилтыг цэгэн зорилт бус, интервалтай утгаар тогтоосноор эдийн засгийг мөнгөний зөөлөн бодлогоор дэмжих орон зайг олгож буйг онцлох нь зүйтэй. Тухайлбал, цар тахлын сорилтын үед бодлогын хүүг түүхэн доод түвшинд хадгалан иргэд, аж ахуйн нэгжүүдийн санхүүжилтийн зардал, зээлийн хүүг бага байлгахад чухал хөшүүрэг болж байна. Иймд түр зуурын шалтгаанаар инфляц зорилтоос давахыг зөвшөөрөх ч дунд хугацаанд 6+/-2% интервалд хадгалах зорилго хэвээр үргэлжилнэ. өөрөөр хэлбэл, цар тахлын үед нийлүүлэлтийн эсвэл ачаа барааны тээврийн шалтгаанаар зарим бараа бүтээгдэхүүний үнэ хэлбэлзэх эрсдэл үүсч болох ч, мөнгөний бодлогын хариу үйлдлийг эдийн засгийн идэвхжилээс хамааруулан тохируулга хийнэ гэсэн үг. Мэдээж зарим нэг тохируулгын арга хэмжээг аваад

эхэлчихсэн.

2021 онд Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсноор банкны системд реформын шинжтэй өөрчлөлтүүд хийгдэж байна. Энэ хүрээнд системийн нөлөө бүхий банкууд хөрөнгийн зах зээлд гарч, олон нийтэд хувьцаагаа санал болгох тун дөхжээ. Монголбанк 2022 онд банкны салбарын тогтвортой байдлыг хангах чиглэлд ямар бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бэ?

-Энэ чиглэлд гурван үндсэн зорилтыг дэвшүүлээд байна. **Нэгдүгээрт**, цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хүрээнд мөрдөгдөж буй зохицуулалтыг ердийн нөхцөлд шилжүүлэх төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Монголбанк Ковид-19 цар

тахлаас үүдэн 2020 онд эдийн засаг болон санхүүгийн мөчлөгийн огцом уналт бий болж, санхүүгийн системд эрсдэл хуримтлагдах нөхцөл байдал үүссэнийг харгалзан иргэд, аж ахуйн нэгжүүдийг хамгаалах, банкны секторын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн зохицуулалтын арга хэмжээг шуурхай хэрэгжүүлсэн. Тухайлбал, төлбөрийн хүндрэлд орсон 146,704 зээлдэгчийн 1.2 их наяд төгрөгийн хэрэглээний зээл, 2,249 ААН-ийн 2.6 их наяд төгрөгийн бизнесийн зээл, 59,926 өрхийн 3.1 их наяд төгрөгийн ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулаад байна (2021 оны 6 дугаар сарын байдлаар). Өөрөөр хэлбэл, банкны системээс гаргасан нийт зээлийн 27.2 хувьд бүтцийн өөрчлөлт хийжээ. Цаашид цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хүрээнд мөрдүүлж буй зохицуулалтыг ердийн нөхцөлд шилжүүлэх төлөвлөгөөг 2021 оны 6 дугаар сард баталсны дагуу банкны үйл ажиллагааны зохистой харьцаа, актив хөрөнгийг ангилахтай холбоотой шаардлагуудыг шат дараатайгаар хэвийн горимд шилжүүлэх болно. Ингэхдээ эдийн засгийн сэргэлттэй уялдуулан шат дараатай арга хэмжээ авах юм.

Хоёрдугаарт, банкны IPO нь 2022 оны эдийн засаг, санхүүгийн зах зээлд нөлөөлөх томоохон үйл явдал байна. Банкны тухай хуулийн өөрчлөлтөөр банкны

системд нөлөө бүхий банкний нээлттэй хувьцаат компани, бусад банкнийг хувьцаат компани хэлбэртэй байх зохицуулалт орсон. Иймд хувьцаат компани хэлбэртэй банкны хяналт шалгалт болон зохицуулалтыг хэрэгжүүлж, системийн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ хөрөнгө оруулагчдад таатай орчныг бүрдүүлэх нь ирэх оны нэг том зорилт, ажил болоод байна.

Гуравдугаарт, Монголбанк банкны салбарын эрх зүйн орчин, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох ажлаа тасралтгүй үргэлжлүүлж, хууль тогтоогч байгууллагатай хамтран ажиллана.

Технологийн хөгжилтэй зэрэгцээд дотоодод финтек компаниудын тоо нэмэгдэж, олон төрлийн төлбөрийн үйлчилгээг санал болгож байна. Монголбанк төлбөр тооцооны энэхүү хөгжлийг хэрхэн хүлээн авч байна вэ. Мөн криптовалют, койны талаар ямар байр суурьтай байна вэ?

-Монголбанк санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх зорилгын хүрээнд шинэ технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг дэмжих бодлого баримталж байгаа. Ингэхдээ Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг сайжруулж, төлбөрийн систем дэх хяналтын чиг үүргээ хэрэгжүүлнэ. Технологийн хурдацтай хөгжилтэй зэрэгцэн Монголд төдийгүй дэлхийн

бусад орнуудын зохицуулагч байгууллагуудын бодлого шийдвэр, зохицуулалтын орчин, дотоод зохион байгуулалт нь хурдацтай даган шинэчлэгдэж буй. Тиймээс шаардлагатай зохицуулалтын орчныг тухай бүр шинэчилж, төлбөрийн системд тавих хяналтыг хэрэгжүүлэх шаардлагатай юм. Энэ нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, иргэдийн төгрөгт итгэх итгэл, эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд чухал нөлөөтэй. Харин сүүлийн үед зах зээлд гараад буй криптовалют, койнууд нь үүнээс өөр буюу албан ёсны төлбөрийн хэрэгсэл биш бөгөөд иргэд оруулсан мөнгөө бүгдийг нь алдах эсвэл мөнгө угаалт, залилангийн гэмт хэргийн хохирогч болох ч эрсдэлтэй гэдгийг анхааруулсаар байна. Монголбанканд ажлын хэсэг байгуулагдан дижитал мөнгө, цахим мөнгөний талаарх томоохон хэмжээний судалгаа хийгдэж байна..

2020 оны 10 дугаар сард ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүүг 6% хүргэж бууруулсан. Цаашид Монголбанк орон сууцны зээлийн хөтөлбөрийг үргэлжлүүлэх үү. Цар тахлын хүнд үед Засгийн газартай хэрхэн уялдаж ажиллах вэ?

-Анх хөтөлбөрийг анх хэрэгжиж эхэлснээс хойш 95 мянга гаруй хүн хамрагдаж орон сууцтай болсон байна. Хүүг бууруулж 6%

болгосноос хойш л гэхэд 6,288 өрхөд 457.2 тэрбум төгрөгийн зээл олгогдсон. Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр нь дундаж орлоготой өрхүүдийн орон сууцны нөхцөлийг сайжруулах, агаар, орчны бохирдол болон орон нутгийн шилжилт хөдөлгөөнийг бууруулах зэрэг бидэнд тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэх олон талын ач холбогдолтой. Гэхдээ хөнгөлөлттэй санхүүжилт учир Төв банкны мөнгөний бодлогын зорилттой нийцдэггүй. Тиймээс үндсэн чиглэлийн төсөлд тусгаснаар Монголбанк ипотекийн зээлийн хөтөлбөрийг 2023 онд багтаан Засгийн газарт шат дараатай шилжүүлэхээр төлөвлөж байна. Засгийн газрын хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх ₮10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хугацаанд Засгийн газар, Монголбанк болон банкуудын эх үүсвэрээр зээлийг шийдвэрлэнэ гэсэн үг. Нийгмийн олон талын ач холбогдолтой хөтөлбөр учир тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх хүртэлх хугацаанд хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх нь зүйтэй гэж төв банк үзэж буй юм. Урт хугацаандаа олон улсын жишигт нийцсэн тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх нь илүү чухал.

Мөн ирэх жил ₮10 их наядын хөтөлбөрийн хүрээнд гарч буй ажлын байр, хөдөө аж ахуйг

дэмжих, репо санхүүжилтийн зээл болон бусад төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хяналтыг үргэлжлүүлж, Засгийн газартай уялдаа холбоотой ажиллана.

Цар тахлын үеийн эдийн засгийн сорилтуудаас гадна Монгол Улсад урт хугацаанд шийдвэрлэх шаардлагатай олон асуудлыг энэ удаагийн төсөлд тусгасан байна. Тэгш бус байдал, байгаль орчны асуудлууд нь одоо л анхаарлаа хандуулахгүй бол ирээдүйд эдийн засаг, санхүүгийн системд эрсдэл учруулах зүйлс мөн үү?

-Дэлхий нийтээрээ л уур амьсгалын өөрчлөлт, эдийн засгийн тэгш бус байдлын сөрөг нөлөөллийг хэрхэн бууруулах вэ гэдэг дээр анхаарлаа хандуулж байна. Монгол Улсын хувьд ч ялангуяа, цар тахлын үеийн эдийн засгийн хүндрэлд нийгмийн эмзэг бүлгүүд илүү өртөж, эдийн засгийн өсөлтийн хүртээмжтэй байдлын ач холбогдлыг улам нэмэгдүүлж байна. Төв банк эдийн засгийн бодлогын гол институцийн хувьд макро эдийн засгийн тогтвортой байдлын талаас ч тэр, санхүүгийн салбарын тогтвортой байдал болон хөгжил, санхүүгийн хүртээмж болон гүнзгийрэлт, засаглалын чанараар дамжуулан хүртээмжтэй өсөлтийг бий болгох хөрсийг бүрдүүлэхэд анхаарна. Уур амьсгалын өөрчлөлтийн хувьд зөвхөн мал аж ахуй, газар



Цаашид цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хүрээнд мөрдүүлж буй зохицуулалтыг ердийн нөхцөлд шилжүүлэх төлөвлөгөөг 2021 оны 6 дугаар сард баталсны дагуу банкны үйл ажиллагааны зохистой харьцаа, актив хөрөнгийг ангилахтай холбоотой шаардлагуудыг шат дараатайгаар хэвийн горимд шилжүүлэх болно.



тариалан гэлтгүй эдийн засгийн бүхий л салбарт нөлөөлж, улмаар санхүүгийн секторт тусгалаа олох эрсдэл юм. Иймд хүрээлэн буй орчин доройтох нь эдийн засгийг улам л эмзэг болгох тул зайлшгүй анхаарал хандуулах сэдэв. Эдгээр асуудалд зохицуулагч байгууллагууд хамтран дорвитой шийдэл, гарах гарц, гаргалгааг бий болгох нь нэн чухал байна.

Цаг гарган ярилцсанд баярлалаа.

"ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2022 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ"-ИЙН

ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХҮРЭЭНД ЭДИЙН ЗАСАГЧИД БОЛОН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨЛӨӨЛӨЛ БАЙР СУУРИА ИЛЭРХИЙЛЛЭЭ

Монголбанкнаас Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төслийг жил бүр олон нийтэд нээлттэй хэлэлцүүлдэг уламжлалтай. Энэ жилийн хувьд уг хэлэлцүүлгийн агуулга, хүртээмжийг нэмэгдүүлж, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг танилцуулах хүрээнд "Эдийн засгийн хүртээмжтэй өсөлт", "Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой ногоон санхүүжилт" сэдвийн дор зохион байгууллаа. Уг сэдвийн дагуу Монголбанк, Үндэсний хөгжлийн газар, ХХААХҮЯ, Дэлхийн Банк, Олон Улсын Санхүүгийн Корпорац, ТоС Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс судалгааны ажлуудаа танилцуулж хэлэлцүүлсэн юм. Эдгээр илтгэлүүдэд судлаачдын дэвшүүлсэн байр суурийг энэхүү буландаа онцлов.



Ч.ДЭЛГЭРЖАРГАЛ
(Монголбанкны
Мөнгөний бодлогын
газрын ахлах эдийн
засагч)

Ковид-19 цар тахалын үеийн эдийн засгийн хүндрэл нь нийгмийн эмзэг бүлгүүдэд илүү хүнд тусч байгаагаас эдийн засгийн өсөлтийн хүртээмжтэй байдлыг бодлого боловсруулагчид давхар харгалзан үзэх нь нэн чухал гэдгийг дэлхий нийт онцолсоор байна. Хүртээмжтэй өсөлт нь эдийн засгийн өсөлт, түүний тогтвортой байдлыг хангах, ирээдүй үеийнхнийгээ харгалзан хамгаалахын зэрэгцээ нийгмийн бүх бүлэг эдийн засагт тэгш оролцох боломжтой байгаа эсэх, мөн орлогын бус үзүүлэлтүүд болох эрүүл мэнд, боловсрол, нийгмийн оролцооны далайц, чанар зэргийг хамарсан өргөн хүрээний ойлголт юм. Өсөлтийн хүртээмжтэй байдал нь үе хооронд, нийгмийн бүлэг, үндэс угсаа, газар нутгийн байдлаас үл хамааран хүртэж байх өгөөж бөгөөд энэ хүрээнд 1) тэнцвэртэй өгөөж, 2) оролцоо, 3) боломж, 4) эрх мэдэл гэсэн үндсэн зорилгуудын хүрээнд зангидагдаж асуудлыг авч үзэх учиртай. Монгол Улсын хувьд эдгээр үзүүлэлт сул, шаардлагатай статистик тоон мэдээллийн хүрээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

- Засаглалын чанар
- Мөнгөний болон төсвийн зэрэг макро бодлогын үр ашигтай байдал
- Дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд зэрэг засгийн газраас үзүүлдэг нийгмийн үйлчилгээнүүдийн чанартай, хүртээмжтэй байдал
- Зорилтот бүлэгт чиглэсэн үр ашигтай татвар, татаасын бодлого
- Өсөлтийн тогтвортой, хүртээмжтэй байдлыг (Өрийн, байгалийн баялгийн, байгаль орчин) бий болгоход төрийн бодлогыг илүүтэй чиглүүлэх хэрэгтэй.



Б.ДӨЛГӨӨН
(Үндэсний хөгжлийн
газрын Дэд дарга)

Монгол Улсын эдийн засгийн өсөлт сүүлийн 30 жилийн хугацаанд улам тогтворгүй буюу өсөлтийн стандарт хазайлт нэмэгдсэн байна. Эдийн засаг өсөх нь хэдий сайн дохио ч зарим жилд өндөр, зарим жилд бага өсч, өсөлтийн зөрүү өндөр байгаа нь тогтворгүй байгааг харуулж байна. Гэтэл стандарт хазайлт бага байх тусам илүү тогтвортойд тооцож болно. Эдийн засгийн хэт савалгаа нь хөрөнгө оруулагчид болон эдийн засагт оролцогчдод тодорхойгүй байдал үүсгэхээс өгсүүлэн сөрөг нөлөөтэй байдаг. Иймээс эдийн засгийн эерэг бөгөөд хэт өндөр бус тогтвортой өсөлт нь урт хугацаандаа хамгийн үр дүнтэйг дэлхийн улс орнуудын ковидоос өмнөх өсөлтийн түүхүүдээс харж болно. Манай улсын хувьд огцом хэлбэлзлийн цаад шалтгааны 40 гаруй хувь нь түүхий эдийн үнэ, гадаадын шууд хөрөнгө оруулалт болон Хятад улсын эдийн засгийн өсөлт зэргээс хамаарч байгааг судалгаагаар тогтоосон. Манай эдийн засгийн стандарт хазайлт нь уул уурхайн эдийн засаг давамгайлсан ойролцоо улсууд болох Чили, Австрали, Канад, Перу, Колумб зэрэг улстай харьцуулахад өндөр байна. Харин салбаруудын өсөлтийн хувьд тухайлбал, барилга, санхүү, боловсруулах, худалдаа, үйлдвэрлэл хамгийн өндөр хэлбэлзэлтэй буюу илүү тогтворгүй байгааг харж болно. Уул уурхайн бус салбарын тогтворгүй байдлыг бууруулахад төсвийн болон мөнгөний бодлого нөлөөтэй. Макро эдийн засгийг тогтворжуулах бодлогыг хэрэгжүүлэхийн тулд уул уурхайн бус салбарын бүтээмжийг анхаарах ёстой. Бүтээмжийг хоёр төрлөөр нэмэгдүүлж болно. Нэгдүгээрт, салбар хоорондын буюу бүтцийн өөрчлөлт хийх, хоёрдугаарт, салбар дотроо бага бүтээмжтэйгээс арай өндөр бүтээмж рүү шилжих гэсэн замууд бий. Энэ төрлийн бодлогыг бодлого боловсруулагчид анхаарч, цаашид бүтцийн шилжилтийг нэмэгдүүлэхгүй бол салбар хоорондын бүтээмжийн өсөлт 2010-2017 онд зогсонги түвшинд байсан.



Ж.ГАНБААТАР
(Дэлхийн банкны
зөвлөх)

Дэлхийн банкны үндсэн зорилгод дараах 2 зүйл багтдаг. Нэгт, ядуурлыг бууруулах. Нэн ядуурлыг 2030 онд 3 хувьд хүргэх. Дэлхий дахинд цар тахалтай холбоотойгоор нэн ядуу хүний тоо 644 сая хүнээс 730 сая хүн болж өсөхөөр байна. Хоёрт, хүртээмжтэй өсөлт. Өсөлт, хөгжлийг жигд хуваарилах шаардлагатай. Хамгийн бага орлоготой 40 хувийн орлого, хэрэглээ өссөн байх явдал. Азийн бүс нутгийн хувьд нэлээд амжилттай буюу энэ үзүүлэлт нь 2012-2017 онд зарим улсын хувьд 4-өөс 8 хувийн өсөлттэй байгаа бол Монгол Улс 1 хувийн өсөлттэй байна. Яагаад хүртээмжтэй өсөлт шаардлагатай вэ? Энэ тухай ярихын тулд эхлээд шударга ёсны асуудал тавигдана. 1960-аад оны АНУ-ын жишээг дурдахад компанийн жирийн ажилтаны цалинг захиралтай нь харьцуулахад 25 дахин бага байсан. Одоо энэ харьцаа 250-иас 300 гэсэн тооцоо гарсан байна. Дараа нь алдагдсан боломжийн тухай юм. Хүртээмжтэй бус байдал нь эргээд өсөлтөд сөрөг нөлөөтэй. Ялангуяа, хүүхдүүдэд тэгш боломж олгогдохгүй байснаар эргээд урт хугацааны сайн сайхан байдалд муугаар нөлөөлнө. Нийгмийн тогтворгүй байдал Хүртээмжтэй өсөлт нь хөгжлийн цорын ганц зам юм. Дэлхийн банк цаашид Монгол Улстай хамтран ажиллах стратегийг гурван баганад төлөвлөөд байна.

- Засаглал: төсвийн менежмент, санхүүгийн тогтвортой байдал засаглал, хариуцлагын тогтолцоо
- Бизнесийн орчин: ЖДҮ санхүүжилтийн хүртээмжтэй байдал, дэд бүтэц, уул уурхайгаас бусад салбарын бүтээмжийг дээшлүүлэх, тогтвортой уул уурхай
- Хүн: эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын систем, хотжилтын асуудлууд зэрэг байх юм.



Г.МӨНХБАЯР
(Монголбанкны
Мөнгөний бодлогын
газрын эдийн засагч)

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шок, эрсдэлүүд санхүүгийн тогтвортой байдлын эрсдэлийн шинэ үүсвэр болж байгаа бөгөөд олон сувгаар дамжин мөнгөний бодлогын шилжих суваг, үйл ажиллагаанд нөлөө үзүүлэхээр байна. Төв банк, санхүүгийн зохицуулагч байгууллагуудын хувьд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулах, тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан олон арга хэмжээг хэрэгжүүлж байгаа ч ерөнхийд нь Мөнгөний бодлого, Санхүүгийн тогтвортой байдал ба бусад бодлогууд гэсэн гурван төрөлд ангилагдаж байна. Эдгээрээс Монголбанкны зорилт, үйл ажиллагаанд нийцэх арга хэмжээнүүдийн хооронд харьцуулан судалж хэрэгжүүлэх боломжтой бодлогын арга хэрэгслүүдийг тодорхойлох нь чухал юм. Мөн, төв банкууд өөрсдийн макро эдийн засгийн төсөөлөл, тооцоололд ашиглаж буй загваруудад цаг уурын эрсдэлийг харгалзан үзэх, нэмж оруулах замаар загвараа сайжруулах шаардлагатай байна. 2019 онд Монгол Улсын Ногоон таксономиг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр баталсан. Үүнтэй холбоотойгоор 2020 оны 1 дүгээр улирлаас эхлэн ногоон зээлийн статистикийг Монголбанкнаас олон нийтэд мэдээлдэг болсон. Нийт ногоон зээлийн үлдэгдлийг авч үзвэл сүүлийн нэг жил хагасын хугацаанд 22.6 хувиар буурч 348.8 тэрбум төгрөг байна. Энэ нь банкны салбарын нийт зээлийн 2 хүрэхгүй хувийг эзэлж байгаа нь хангалтгүй үзүүлэлт тул цаашид ногоон санхүүжилт, тогтвортой хөгжлийн зорилтыг дэмжиж, арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай. Ингэхдээ төрийн болон олон улсын холбогдох байгууллагуудтай хамтран уур амьсгалын өрчлөлт, дэлхийн дулаарлын Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлж буй нөлөө, үр дагаврын талаарх цогц судалгааг хийж гүйцэтгэх, тогтвортой санхүүжилтийн чиглэлээр баримтлах бодлого, стратеги боловсруулж, хэрэгжүүлэх нь чухал юм.



Д.БАТМӨНХ
(ХХАХҮЯ-ны Мал
аж ахуйн бодлогын
хэрэгжилтийг
зохицуулах газрын
дарга /Ph.D./)

Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд цаг агаарын үндсэн үзүүлэлтүүд болох байгалийн хур тунадас, агаарын температур, салхины хурд чиглэл, чийгшил шууд нөлөөтэй, урт хугацаанд хамааралтай байх төлөвтэй. Эх газрын эрс тэс уур амьсгалтай манай орны нөхцөлд усалгаагүй газар тариалан эрхлэхэд нэн эрсдэлтэй. Малын тоо толгойн өсөлтөд ч байгалийн хүчин зүйлийн нөлөө их байсаар ирсэн. Иймд мал аж ахуй, газар тариаланд цаг уурын мэдээлэл, үйлчилгээний хүрээг өргөтгөх зайлшгүй шаардлага бий болсон. Уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын мэдээлэл нь салбарын эрсдэлийг бууруулах, арга хэмжээ төлөвлөх, хэрэгжилтийг хангах ач холбогдолтой хэрэгцээ нь улам өсөж байна. Өөрөөр хэлбэл, хур тунадас, температур, агаарын чийгшилт, салхины үзүүлэлтүүдийн богино болон урт хугацааны нөлөөлөл, магадлалыг тогтоох судалгааны ажлуудыг өргөн хүрээтэй явуулж, үр дүнд тулгуурлан тогтвортой газар тариалан, мал аж ахуй, эрхлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна. Салбарын бодлогод уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх, хөгжүүлэх, тооноос чанарт

шилжүүлэх, мэргэжлийн ажил үйлчилгээг төлөвшүүлэх, бэлчээрийн ашиглалт хамгаалалтын эрх зүйн орчинг бүрдүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлд үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх асуудал бүрэн тусгагдсан. МАА-н салбарын тулгуур хоёр багана болох Хөнгөн болон хүнсний үйлдвэрлэлийн боловсруулах хүчин чадлыг ашиглалтыг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, энэ чиглэлд ногоон санхүүжилтийг ашиглах, цаг агаарын өөрчлөлтөд дасан зохицож амьдрах шаардлага бий болсон байна.



Б.БАТМӨНХ
(ОУСК-ийн Санхүүгийн
салбарын ахлах
мэргэжилтэн)

Уур амьсгалын өөрчлөлт нь шууд биет болон шилжилтийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлүүдийг бий болгож байгаа бөгөөд улс орнуудын зохицуулагч байгууллагуудаас энэ асуудлыг маш их анхааран зохицуулалтын хууль журмандаа өөрчлөлт оруулан ажиллаж байна. Учир нь эдгээр эрсдэлүүд нь зээлдэгч, харилцагчдын бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, энэ нь эргээд санхүүгийн байгууллагуудын зээлийн чанар, ашигт ажиллагаанд нөлөөлөн салбарын тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй түвшинд хэдийнээ очсон. Дээр нь нэмээд уур амьсгалийн өөрчлөлтөөс шалтгаалан өөрчлөгдөж буй зах зээлийн чиг хандлага, дүрэм журам, шаардлагуудад дасан зохицох, үйл ажиллагаагаа өөрчлөхтэй холбоотой эрсдэлд санхүүгийн байгууллагууд бэлэн байх шаардлагатай тулгарч байна. Ногоон төсөл, хөтөлбөрүүдэд санхүүжилтийг чиглүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, ногоон хөгжлийн зорилуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг дайчлахад Ногоон бондын үүрэг, ач холбогдол нэмэгдсээр байна. Ердийн компанийн өрийн хэрэгсэлтэй харьцуулахад ногоон бонд нь нэг гол онцлогтой. Тухайлбал, бондын эх үүсвэрийг гагцхүү уур амьсгал, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх шинэ болон одоо хэрэгжүүлж буй төслүүдэд зарцуулах явдал юм. Эдгээр төслүүд нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг нөлөөллийг бууруулах эсхүл дасан зохицох буюу тэсвэрлэх чадварыг сайжруулах, байгалийн нөөцийн зүй бус хэрэглээ, биологийн олон янз байдал алдагдах, агаар, ус, хөрсний бохирдлыг арилгах, бохирдлоос сэргийлэх зэрэг байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэх, бууруулахад чиглэсэн байдагдлаартай байж болно.



М.БОЛДОО
(ТоС Холбооны
Гүйцэтгэх захирлын
үүрэг гүйцэтгэгч)

Монголбанк Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийг анхнаас нь дэмжин ажиллаж, 2019 оны Мөнгөний бодлогод тусгасан Ногоон таксономийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын тогтвортой санхүүгийн холбоо, Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран ногоон эдийн засгийн үйл ажиллагааны тодорхойлолтыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр батлуулсан. Тэгвэл энэхүү үйл ажиллагааг илүү өргөжүүлэн ажиллахаар 2022 оны Мөнгөний бодлогод дараах саналуудыг тусгахаар хэлэлцүүлсэн. Үүнд: Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааны чиг үүрэгт уур амьсгалын эрсдэлийг санхүүгийн салбарт тооцох зорилт нэмж оруулах, Монгол Улсын тогтвортой санхүүжилтийн үндэсний замын зургийг салбарын бодлого, олон улсын чиг хандлага, сайн туршлагатай уялдуулан шинэчлэн сайжруулж Үндэсний тогтвортой санхүүжилтийн стратеги болгон хэрэгжүүлэх, Банкинд байгаль орчин, нийгэм, засаглалын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх журам баталж, энэ хүрээнд БОН-ийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо, уур амьсгалын эрсдэлийн үнэлгээ, тогтвортой тайлагналтай холбогдох аргачлалыг нэвтрүүлэх, Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журамд эрчим хүчний хэмнэлттэй болон ногоон барилгыг санхүүжүүлэх тухай заалт, аргачлалыг нэмж оруулах, Тогтвортой санхүүжилтийг санхүүгийн байгууллагад амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Төв Банкны зүгээс авч хэрэгжүүлэх боломж бүхий урамшуулал, хөшүүргийн арга хэрэгслүүдийг судалж, нэвтрүүлэх, Үндэсний ногоон таксономийг өргөжүүлэн тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан эдийн засгийн үйл ажиллагааны ангилал, шалгуур үзүүлэлт бүхий SDG санхүүжилтийн таксономи боловсруулж мөрдөх, Тогтвортой санхүүжилтийн талаарх олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, уг чиглэлд хийгдэх судалгаа ба эрдэмтэн судлаачдын тоог нэмэгдүүлэх зорилготой чадавх бүрдүүлэх аян зохион байгуулах зэрэг саналыг дэвшүүлж хэлэлцсэн.



Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн зорилт



1. Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:

1.1 Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2022-2024 онд ± 2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулна. Инфляцыг тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогын шийдвэрийг гаргахдаа зах зээлийн зарчимд тулгуурлан нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлтийн шууд бус нөлөөг нягтлан үзэж, эдийн засгийн сэргэлтийг удаашруулахгүй байх зарчмыг баримтлана.

1.2 Ковид-19 цар тахлын хүндрэлийг даван туулах, эдийн засгийн сэргэлт, дунд хугацааны макро тогтвортой байдлыг дэмжсэн зээлийн тогтвортой өсөлтийг хангаж, банкны системд эрсдэл хуримтлагдахаас сэргийлсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

1.3 Төв банкны олон нийттэй харилцах харилцааг хөгжүүлж, бодлогын ил тод байдлыг хадгалж ажиллана.

2. Банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд:



2.1 Эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан банкны салбарын хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын стандартад нийцүүлэх арга хэмжээг үргэлжлүүлж, цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хүрээнд мөрдөгдөж буй зохицуулалтыг ердийн нөхцөлд шилжүүлэх төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.2 Банкны хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулах хууль эрх зүйн шаардлагын хүрээнд хяналт шалгалт, зохицуулалтыг боловсронгуй болгож мөрдүүлнэ.

2.3 Банкны салбарын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд хийсэн судалгаа, үр дүнд үндэслэн эрх зүйн зохицуулалтын давхардал, хийдлийг арилгаж нэгдмэл байдлыг хангах, зээлийн мэдээлэл, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, буцаан худалдан авах барьцаат санхүүжилтийн хэлцлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээ авна.

3. Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:

3.1 Төв банкны цахим мөнгө гаргах талаар судалж, хөгжүүлнэ.

3.2 Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг сайжруулах замаар шинэ технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг дэмжиж, төлбөрийн систем дэх хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.3 Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дэмжинэ.

3.4 Макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн шинжилгээнд их өгөгдлийг ашиглах техникийн болон мэргэшлийн ур чадварыг үе шаттайгаар бүрдүүлж эхлэнэ.



ГУРАВДУГААР УЛИРЛЫН ИНФЛЯЦЫН ТАЙЛАНГИЙН ТОЙМ

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ

Төв банкны тухай хуульд **Монголбанкны үндсэн зорилт нь төгрөгийн тогтвортой байдлыг хангах** гэж тодорхойлсон байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанк хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах бодлогыг “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-д тусган хэрэгжүүлж байна. Инфляцыг нам түвшинд тогтворжуулснаар иргэдийн бодит орлого, хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал хангагдах нөхцөлийг бүрдүүлэх төдийгүй урт хугацаанд хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжинэ. Монголбанк хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн **инфляцыг 2021-2023 онд жилийн 6 хувь орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулахыг** зорьж байна.

Монголбанкнаас мөнгөний бодлогын хүрээнд бодлогын хүүг өөрчилснөөр санхүүгийн зах зээлийн хүү, зээлийн эрэлт, нийлүүлэлтэд, улмаар үйлдвэрлэлийн хэмжээ, хөрөнгийн үнэ, хүлээлт, валютын ханш, дотоод эрэлтэд нөлөөлөх замаар инфляцын түвшинг тогтворжуулахыг зорьдог. Түүнчлэн, 2018 оноос эхлэн макро зохистой

бодлогын хүрээнд системийн хэмжээнд мөрдүүлэхүйц банкны зохистой харьцааны хэрэгслүүдээр дамжуулан банкны зээлийн хэт өсөлт, үүний аль нэг салбар, бүтээгдэхүүн эсхүл гадаад валютад хэт төвлөрсөн байдлыг оновчтой удирдахад чиглэсэн арга хэмжээг бодлогын хүүтэй хослуулан хэрэглэх стратегийг баримталж байна.

Монголбанк зах зээлийн итгэлийг олж, хүлээлтийг удирдах замаар мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулахын тулд олон нийттэй нээлттэй харилцахад ач холбогдол өгч байна. Иймд Монголбанк макро үзүүлэлтүүдийн гүйцэтгэл, инфляц, эдийн засгийн ойрын төлөв байдал, түүнд нөлөөлж буй гадаад эдийн засаг, санхүүгийн салбар, нийт эрэлт, нийлүүлэлт, ажил эрхлэлт, үнэ ба зардлын хүчин зүйлс зэргийг Инфляцын тайланд танилцуулж, улирал тутам олон нийтийн хүртээл болгож байна. Төв банкны зорилтод нийцтэй, инфляцын төсөөлөлд үндэслэн авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээ, мөнгөний бодлогын шийдвэр гаргагчдын зорилтыг олон нийтэд ийнхүү нээлттэй танилцуулснаар Монголбанкны бодлогын ил тод байдлыг хангах, Монголбанкинд итгэх итгэлийг дээшлүүлэх замаар зах зээлд оролцогчдын хүлээлтийг удирдах ач холбогдолтой.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2021 оны 9-р сарын 16-ны өдрийн ээлжит хурлаар:

1. Бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах;
2. Урт хугацаат дахин санхүүжилтийн хэмжээг 2021 оны 4-р улиралд 100 хүртэлх тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх шийдвэрийг гаргалаа.

ТОЙМ

Гадаад эдийн засгийн орчин сайжирч, эдийн засаг алгуур сэргэх хүлээлт хэвээр байгаа хэдий ч КОВИД-19 вирусийн дотоод тархалт буурахгүй байгаа нь эдийн засагт томоохон эрсдэл болсоор байна. Эдийн засгийн идэвхжлийг даган эрэлтийн шалтгаантайгаар үнэ алгуур өсөх боловч сүүлийн саруудад инфляц эрчимжиж, түүний багагүй хэсгийг¹ нийлүүлэлтийн болон нэг удаагийн шинжтэй нөлөө бүрдүүлж байна.

¹ 2021 оны 8 дугаар сард хэрэглээний сагсны 19 хувийг бүрдүүлдэг шатахуун, мах, сайжруулсан түлшний үнэ нийт инфляцын 45 хувийг тайлбарлаж байна.

Инфляц нэмэгдэх хандлага ирэх улирлуудад үргэлжлэх боловч Төв банкны зорилтот түвшний орчимд тогтворжих хандлага хэвээр байна. 2021 оны 8 дугаар сард инфляц улсын хэмжээнд 8.9 хувь, Улаанбаатар хотод 9.1 хувьд хүрч нэмэгдэхэд нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлс голлон нөлөөллөө. Тодруулбал, 1) махны үнэ 6-р сард улирлын хандлагаасаа давж өссөн; 2) хилийн боомтууд дээрх ачаалалтай холбоотойгоор импортын барааны үнэ өмнөх төсөөллөөс өндөр гарсан; 3) шатахууны үнэ 7 дугаар сард төрлөөсөө хамааран 200-600 төгрөгөөр нэмэгдэж, үүнтэй холбоотой шатахууны үнийн дам нөлөө



бусад бараа бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлж байгаа зэрэг нь голчлон нөлөөлөв. Харин нөгөө талаас хатуу түлшний үнийг Засгийн газраас дахин хямдруулах хүлээлттэй байгаа нь ирэх саруудад инфляц буурах нөлөө үзүүлэхээр байна. Богино хугацаанд инфляц суурь үеийн болон нэг удаагийн шинжтэй нөлөөгөөр Төв банкны зорилтыг даваад байгаа ч 2022 оны сүүлийн хагасаас Төв банкны зорилтын орчимд тогтворжино. Эрэлтийн шалтгаантай инфляц эдийн засгийн идэвхжлийг даган алгуур нэмэгдэж, 2022-2023 онуудад инфляц зорилтот түвшний орчимд хадгалагдах тооцоолол хэвээр хадгалагдаж байна.

Эдийн засгийн өсөлтийн төлөвийг өмнөх төсөөллөөс буурууллаа. 2021 оны 2-р улиралд эдийн засгийн өсөлт хүлээлтээс бага гарсан бөгөөд нүүрсний экспорт болон төмрийн хүдрийн олборлолт буурсан, мөн зэсийн баяжмал дахь металлын агууламж төсөөллөөс бага байсан нь уул уурхайн салбарын өсөлт саарахад нөлөөлжээ. Харин уул уурхайн бус салбарт тээвэрлэлтийн хязгаарлалт, логикийн саатал, хөл хорионы сөрөг нөлөөгөөр барилга, боловсруулах, үйлчилгээний салбар хүлээлтээс багаар идэвхжлээ. Мөн эдгээр хүчин зүйлсээс гадна төсөөллийн зөрүүнд ДНБ-ий зэрэгцүүлэх үнийн тооцооны аргачлал, суурь он өөрчлөгдсөн болон 2020 оны ДНБ-ний гүйцэтгэл шинэчлэгдсэн нь нөлөөлөв. Эрэлт талаас хөрөнгө оруулалт сэргэн эдийн засгийн өсөлтийг тэтгэж байгаа ч өрхийн хэрэглээ сүүлийн гурван улирал дараалан агшсан, мөн экспорт буурсан нь өсөлтөд сөрөг нөлөө үзүүлээд байна. Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв КОВИД-19 вирусийн дотоод тархалт, ажил эрхлэлт, өрхийн орлого, хэрэглээ хэрхэн өөрчлөгдөхөөс шууд хамааралтай. Эдийн засгийн өсөлтийн төлөвийг гол салбараар нь авч үзвэл уул уурхайн салбар 2 дугаар улиралд саарсан хандлага оны сүүлийн хагаст үргэлжилж нийт өсөлтийг өмнөх төсөөллөөс бууруулахаар байна. Харин уул уурхайн бус салбарын хувьд оны сүүлийн хагаст Засгийн газар болон Төв банкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийг сэргээх бодлогын арга хэмжээ, гадаад орчны сэргэлттэй уялдан эрчимжинэ гэж үзэв. Ийнхүү уул уурхайн бус салбар оны сүүлийн хагаст идэвхжихээр байгаа ч вирусийн шинэ хувилбар, тархалт нэмэгдэж байгаа нь эдийн засагт томоохон эрсдэлийг нэмэгдүүлсэн хэвээр байна.

Дунд хугацаанд зэсийн баяжмал, түүний агууламж буурах хүлээлттэй байгаа нь уул уурхайн үйлдвэрлэлийг бууруулах нөлөө үзүүлэх ч бусад салбарууд цар тахалтай холбоотой уналтаас гарч урт хугацааны хэвийн түвшиндээ хүрэх, мөн гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэх нөлөөгөөр дотоод эрэлт сэргэж уул уурхайн бус салбар эрчимжин эдийн засгийн өсөлтийг дэмжихээр байна.

Мөнгө, зээлийн өсөлт үргэлжилж байна. 2021 оны 7 дугаар сарын байдлаар М2 мөнгө жилийн 26.5 хувиар нэмэгдлээ. Сүүлийн 1 жилийн хугацаанд гадаад валютын албан нөөцийн хуримтлал 1 сая ам.доллараар өсч М2 мөнгөний өсөлтийг нэмэгдүүлсэн хэдий ч сүүлийн саруудад төлбөрийн тэнцлийн алдагдалтай холбоотой мөнгөний нийлүүлэлтийн гадаад эх үүсвэрийн өсөлт саарч байна. Мөн "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний хэрэгжилттэй холбоотойгоор зээл олголт сэргэж, өнгөрсөн онд 4-5 хувиар агшиж байсан нийт зээлийн үлдэгдэл энэ оны 7 дугаар сарын байдлаар жилийн 12.3 хувиар өссөн байна.

Гадаад орчинд эерэг өөрчлөлтүүд бий болж байна. Томоохон эдийн засагтай орнуудын 2021 оны 2-р улирлын эдийн засгийн өсөлт хүлээлтээс өндөр гарсны дээр АНУ, ОХУ, Евро бүсийн 2021 оны өсөлтийн төсөөлөл нэмэгдлээ. Хэдийгээр гадаад орчинд цар тахлын шинэ давалгаанууд үүсч дэлхийн эдийн засгийн идэвхжилд сөргөөр нөлөөлж байгаа боловч тархалтыг хяналтад оруулах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх чадамж нэмэгдэж байгаагийн зэрэгцээ эдийн засгийн сэргэлтийн хүлээлт харьцангуй өөдрөг хэвээр байна. Цаашид КОВИД-19 вирусийн эсрэг вакцины хүрэлцээ, үйлдвэрлэлийн чадамж, вакцинжуулах хурд, вирусийн шинэ хувилбарын тархалт зэргээс гадаад эрэлтийн ерөнхий төлөв хамаарахаар байна.

Гадаад эрэлт өмнөх төсөөллөөс сайжран дэлхийн зах зээл дээрх эрдэс түүхий эдийн үнэ нэмэгдээд байна. Тодруулбал, манай экспортын гол бүтээгдэхүүнүүд болох зэс, нүүрс, төмрийн хүдэр, газрын тосны үнэ өсч 2021 оны гадаад худалдааны нөхцөлийн төсөөлөл өмнөх төсөөллөөс сайжраад байна.

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2021 оны 2 дугаар улиралд -224.6 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 104.4 сая ам.доллараар буурлаа. Багцын хөрөнгө оруулалтын гарах урсгал багасч, худалдааны зээлийн ашиглалт нэмэгдэн, санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн нь нөлөөлөв. Харин экспорт өсч, үйлчилгээний дансны алдагдал агшсан хэдий ч импорт хурдтай тэлж, орлогын дансны алдагдал тэлсэн нөлөөгөөр урсгал дансны алдагдал өмнөх оны мөн үеэс тэлсэн байна. Энэ онд түүхий эдийн үнэ өндөр байгаа нь экспортын орлогыг дэмжиж байгаа ч хилийн боомтууд дээрх удаашралтай холбоотойгоор экспортын биет хэмжээ бууран төлбөрийн тэнцэлд сөрөг нөлөө үзүүлж байна.



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН ХУРАЛДААН ХУВААРИЙН ДАГУУ ХУРАЛДАЖ, **2021 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 16-НЫ ӨДӨР БОДЛОГЫН ШИЙДВЭРЭЭ ТАНИЛЦУУЛЛАА.** ТУС ШИЙДВЭРИЙГ ТАНИЛЦУУЛАХ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛЫН ЭХЭНД МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭНГИЙН БОДЛОГЫН ШИЙДВЭР ГАРГАЛТЫН ТАЛААР ТАЙЛБАРЛАЖ ХЭЛСЭН ҮГИЙГ БҮРЭН ЭХЭЭР НЬ ХҮРГЭЭ.

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе!

Сүүлийн жил гаруй хугацаанд цар тахлаас үүдэлтэй нийтийн эрүүл мэндийн хямралаас шалтгаалсан эдийн засгийн хүндрэлийг даван туулахын тулд дэлхий нийтээр тэмцэж

байна. Монгол Улсын хүн амын 65 хувь КОВИД-19-ийн вакцинжуулалтад бүрэн хамрагдаад байгаа ч цар тахлын тархалт дахин нэмэгдэж, тодорхой бус байдал төдийлөн буурахгүй байна. Эдийн засгийн хүндхэн

сорилттой энэ цаг үед Төв банкны мөнгөний бодлого нь дунд хугацааны үнийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийг сэргэлтийг дэмжихэд чиглэж байна.

**МӨНГӨНИЙ БОДЛОГЫН
ХОРООНЫ 2021 ОНЫ**



**9-Р САРЫН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ШИЙДВЭР, УГ
ШИЙДВЭРИЙГ ГАРГАХАД
ГОЛ ҮНДЭСЛЭЛ БОЛЖ БУЙ
ЭДИЙН ЗАСГИЙН ДОТООД,
ГАДААД ОРЧИН, ЦААШДЫН
ТӨЛӨВ, ХАНДЛАГА ХЭРХЭН
ӨӨРЧЛӨГДӨЖ БУЙ ТАЛААР
МОНГОЛБАНКНЫ БАЙР
СУУРИЙГ ТА БҮХЭНТЭЙ
ХУВААЛЦЪЯ.**

Инфляцыг богино хугацаанд нийлүүлэлтийн хүчин зүйлс голлон тайлбарлаж байна. Цаашид эрэлтийн нөлөөгөөр инфляц алгуур сэргэх хэдий ч Төв банкны зорилтын орчимд тогтворжих хүлээлт

хэвээр байгааг онцлон дурдъя. Инфляц энэ оны 8 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 8.9 хувь, Улаанбаатар хотод 9.1 хувьд хүрч нэмэгдээд байна. Үнийн өсөлтөд нэг талаас эдийн засгийн сэргэлт нөлөөлж байгаа хэдий ч дийлэнх хэсгийг суурь үеийн нөлөө, нэг удаагийн буюу нийлүүлэлтийн шинжтэй болон гадаад хүчин зүйлс тайлбарлаж байна. Жишээ дурдаж хэлэхэд хэрэглээний сагсны 19 хувийг бүрдүүлдэг шатахуун, мах, сайжруулсан түлшний үнэ нийт инфляцын 45 хувийг бүрдүүлж байна. Ийнхүү, богино хугацаанд инфляц суурь үеийн болон гадаад, дотоод нэг удаагийн шинжтэй нөлөөгөөр нэмэгдээд байгаа хэдий ч 2022 оны сүүлийн хагасаас инфляц Төв банкны зорилтын орчимд тогтворжихоор байна. Гэвч богино хугацаанд дэлхийн эдийн засгийн сэргэлт, олон улсын нийлүүлэлтийн сүлжээ, логикийн сааталтай холбоотойгоор гадаад инфляц болон дэлхийн зах зээл дээрх хүнс, шатахууны үнэ хүлээлтээс давж өсөх, дотоод зах зээл дээр нийлүүлэлтийн шалтгаанаар үнэ огцом өсөх тохиолдолд, хүлээлтээс давсан инфляцыг үүсгэж болзошгүй байна.

**ЭДИЙН ЗАСГИЙН
ӨСӨЛТИЙН ТӨЛӨВИЙГ
ӨМНӨХ ТӨСӨӨЛЛӨӨС
БУУРУУЛСАН Ч ҮҮНИЙ**

“**Үнийн өсөлтөд нэг талаас эдийн засгийн сэргэлт нөлөөлж байгаа хэдий ч дийлэнх хэсгийг суурь үеийн нөлөө, нэг удаагийн буюу нийлүүлэлтийн шинжтэй болон гадаад хүчин зүйлс тайлбарлаж байна. Жишээ дурдаж хэлэхэд хэрэглээний сагсны 19 хувийг бүрдүүлдэг шатахуун, мах, сайжруулсан түлшний үнэ нийт инфляцын 45 хувийг бүрдүүлж байна.**”



ТОДОРХОЙ ХЭСЭГ НЬ ДНБ-ИЙ АРГАЧЛАЛ, ТООЦООЛОЛ ШИНЭЧЛЭГДСЭНТЭЙ ХОЛБООТОЙ БАЙНА.

Хилийн хязгаарлалт, вирусийн шинэ хувилбарууд тархаж байгаатай холбоотой эдийн засгийн идэвхжил саарч, өсөлт 2 дугаар улиралд муудсан боловч эдийн засаг 2021 оны эцэст цар тахлын өмнөх буюу 2019 оны түвшинд хүрч сэргэх хүлээлт хэвээр байна. Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөвийг гол салбаруудаар авч үзвэл уул уурхайн салбар 2 дугаар улиралд саарсан хандлага оны сүүлийн хагаст үргэлжилж, үлдсэн хугацаанд нийт өсөлтөд дэмжлэг үзүүлэхээргүй байна. Харин уул уурхайн бус салбарын хувьд оны сүүлийн хагаст Засгийн газар болон Төв банкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийг сэргээх бодлогын арга хэмжээ,

гадаад орчны сэргэлттэй уялдан эрчимжих хүлээлттэй байна. Улмаар уул уурхайн бус салбарын үйлдвэрлэлийн сөрөг зөрүү хаагдах хугацаа 1 улирлаар наашилж 2021 оны эцэст хаагдах хүлээлттэй байгааг энд онцолмоор байна.

Ирэх онд зэсийн баяжмалын агууламжийн өөрчлөлттэй холбоотойгоор тус салбарын өсөлт саарах бол уул уурхайн бус салбарын өсөлт ирэх жилийн эдийн засгийн өсөлтийг голлон тэтгэх хүлээлттэй байна. Түүнчлэн гадаадын шууд хөрөнгө оруулалт, экспортын орлогын өсөлт эдийн засгийн дотоод эрэлтийг нэмэгдүүлнэ.

ЦАР ТАХАЛТАЙ НҮҮР ТУЛСАН 2020-2021 ОНД МОНГОЛБАНКНААС МӨНГӨНИЙ БОДЛОГО,

МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГО, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГ МӨЧЛӨГ СӨРСӨН БАЙДЛААР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА БИЛЭЭ.

Бодлого, зохицуулалтын арга хэмжээний нөлөөгөөр санхүүгийн нөхцөл зөөлөрч, эдийн засгийн сэргэлтийг дэмжиж байна. “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх ₮10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилттэй холбоотойгоор зээл олголт сэргэж 2021 оны 7 дугаар сарын байдлаар банкны системийн зээлийн үлдэгдэл жилийн 12.3 хувиар өслөө. Түүнчлэн, шинээр олгосон зээлийн дундаж хүү энэ оны 7 дугаар сарын байдлаар 12.8 хувь болж, 1 дүгээр сарын түвшнээс 2.4 нэгж хувиар буурсан байна. Бодлогын өнөөгийн төлөв нь инфляцын

зорилттой нийцтэй байгаа бөгөөд Төв банк эдийн засгийн сэргэлтийг удаашруулахгүйгээр дунд хугацааны инфляцын зорилтоо биелүүлэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээнүүдийг шат дараатай авч хэрэгжүүлнэ.

Мөнгөний бодлогын хорооны өмнөх хурлаас хойш дэлхийн эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, худалдааны гол түнш орнуудын өсөлтийн төлөв сайжирлаа. Тухайлбал, АНУ, ОХУ, Евро бүс зэрэг томоохон эдийн засгийн өсөлт энэ оны 2-р улиралд хүлээлтээс өндөр байсны зэрэгцээ 2021, 2022 оны төсөөллөө нэмэгдүүлээд байна. Улс орнуудын цар тахлын сөрөг нөлөөг бууруулах бодлогын арга хэмжээ болон вакцинжуулалтын явц нь сэргэлтэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Гэсэн хэдий ч КОВИД-19 вирусийн шинэ хувилбаруудын тархалт нэмэгдэж байгаа нь гадаад эдийн засгийн идэвхжилд сөргөөр нөлөөлж болзошгүйг бодлого боловсруулах, зохицуулалт хэрэгжүүлэх бүх шатандаа анхаарах нь зүйтэй.

Дэлхийн эдийн засгийн сэргэлт түүхий эдийн үнийн өсөлтөөр дамжин манай экспортын орлогод дэмжлэг үзүүлж байна. Энэ оны 7 дугаар сарын байдлаар экспортын үнэ жилийн 34.6 хувиар, импортын үнэ 18.6 хувиар өсч, гадаад худалдааны нөхцөл жилийн 13.6 хувиар

сайжирлаа. Тодруулж хэлбэл нүүрс, төмрийн хүдэр, газрын тосны экспортын үнийн төсөөлөл нэмэгдэн, гадаад худалдааны нөхцөл энэ онд үргэлжлэн сайжрах хүлээлттэй байна. Хэдийгээр гадаад эрэлт сайжирсан ч манай экспортын биет хэмжээ төдийлөн сэргэхгүй байна. Нүүрсний экспортын тээвэр сүүлийн 6 сарын туршид удааширч, нийт экспорт эхний 7 сард хүлээлтээс багаар буюу 18.3 хувиар өслөө. Харин дотоод эдийн засгийн идэвхжил, уул уурхайн томоохон төсөл, дэд бүтцийн бүтээн байгуулалтууд, дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ зэргээс үүдэн импорт оны эхний 7 сард 31.9 хувиар тэллээ. Ийнхүү импорт экспортоос хурдтай өссөн нөлөөгөөр урсгал тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 2 дахин тэлээд байна. Төлбөрийн тэнцэл урьдчилсан гүйцэтгэлээр оны эхний 7 сард 300 сая ам.долларын алдагдалтай байгаа хэдий ч энэ онд гадаад валютын нөөц өмнөх оны түвшинд хадгалагдах хүлээлттэй байна.

Миний бие илтгэлийнхээ төгсгөлд цар тахлын хямралыг даван туулахад бидэнтэй идэвхтэй хамтран ажиллаж, дэмжиж буй түнш улс орнууд болон олон улсын санхүүгийн байгууллагуудад талархсанаа илэрхийлье. Цар тахлын энэ хүндрэлийг сайн хөршийн,

сайн түншийн харилцаагаа улам бүр нягтруулж хамтын хүчээр амжилттай даван туулна гэдгийг онцлон тэмдэглэж илтгэлээ өндөрлөө.

Та бүхэнд эрүүл энхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.




СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ


2021 оны

ИНФЛЯЦ

Бодлогын хүү түүхэн доод түвшин 6 хувьд хүрэв.



2021 оны 8 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд инфляц 8.9%-тай гарав



ХҮНСНИЙ ҮНИЙН ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ



Мах, махан бүтээгдэхүүн 15.1%

УЛААНБААТАР ХОТ



Сүү, сүүн бүтээгдэхүүн 9.3%



Төрөл бүрийн өөх, тос 23.7%



Хүнсний ногоо 20.3%



Талх, гурил, будаа 6.8%




Сахар, жимсний чанамал, чихэр, шоколад 6.3%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


2

М2 МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

М2 мөнгөний нийлүүлэлт 2021 оны 8 дугаар сард 27.1 их наяд ₮ хүрч, өмнөх оны мөн үеэс 26.3%-иар өсөв.



М2-ийн өсөлт байршуулалт талаас




М2-ийн өсөлт эх үүсвэр талаас




ЗЭЭЛ

Банкуудын нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 14.4%-иар өсч 19.7 их наяд төгрөгт хүрэв.



2021 оны 8 дугаар сарын байдлаар чанаргүй зээл 10.1%-тай байна.




Зээлийн жилийн өсөлтийн бүтэц, салбарын ангиллаар




ИПОТЕКИЙН ЗЭЭЛ



Ипотекийн нийт зээлийн үлдэгдэл **5,372.0** тэрбум төгрөгт хүрэв.



Шинээр олгосон ипотекийн зээлийн хүү



Зээлдэгчдийн тоо



102,744

Үүнээс:



74%




26%

Эх сурвалж: Монголбанк

ХҮҮ




Зээлийн хүү, хадгаламжийн хүүний зөрүү



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн хүү*, хугацаатай хадгаламжийн хүү
(*хөнгөлөлттэй зээл оруулснаар)




Эх сурвалж: Монголбанк


ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ



Төлбөрийн тэнцлийн динамик, сая ам.доллар



МУ-ын төлбөрийн тэнцэл 2021 оны эхний 7 сарын байдлаар **300.1** сая ам.долларын алдагдалтай гарсан.



Урсгал ба хөрөнгийн дансны бүтэц

Бараа	Анхдагч орлого	Хөрөнгийн данс
\$306.4 сая	-\$1,003.9 сая	\$65.5 сая
Үйлчилгээ	Хоёрдогч орлого	
-\$635.8 сая	\$120.9 сая	

Санхүүгийн дансны бүтэц

Шууд хөрөнгө оруулалт	Багцын хөрөнгө оруулалт
\$1,041.1 сая	-\$108.9 сая
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	Бусад хөрөнгө оруулалт
-\$9.6 сая	-\$4.8 сая

Эх сурвалж: Монголбанк

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

ОЧИРООР ОГТЛОГЧ БУЮУ ДОРЖ ЗОДВА
DORJEZODOVA - "DIAMOND CUTTER"

XIX - XX зуун Болгоомол цаас, есөн эрдэнийн будаг
26 хуудастай 26.5 x 11.6 см 19th - 20th Century Paper
and Ground mineral pigments 26 pages 26.5x11.6 cm X

XIX - XX зуун Болгоомол цаас, нухмал алт 52
хуудастай 21.6 x 8.5 см 19th - 20th Century Paper,
Ground gold 52 pages 21.6 x 8.5 cm



Тус судрыг санскритээр Арьяа Ваджра Чедэка
Нама Пражня Парамита сутра хэмээх ба
түвэд хэлээр Пагва Шейрав Жи Паролду
Чинба Дорж Зодва шэжава Тэгва Чинбой
До, монголоор Хутагт билгийн чанад
хязгаарт хүрсэн Очир огтлогч хэмээх Их
хөлгөн судар оршивой хэмээн нэрлэнэ.
Очир огтлогч нь дэлхий дээр гар бичмэлээр
бус, бараар хэвлэсэн хамгийн эртний номын
нэг юм. Бурхан Будда 2500 жилийн өмнө
амаар айлдсан зарлигийн бичмэл эх бөгөөд
дөрвөн мянган жилийн настай эртний хэл болох
санскритээр айлдсан ба мянга орчим жилийн өмнөөс
түвэд хэлнээ орчуулагдсан байна. Гэвч Очир огтлогч нь
нууцлаг болоод эртний хэлээр айлдсан тул олон зууны
турш мэргэд тайлбарлан бичсээр иржээ. Монголчууд
бурханы ном судрыг эрдэнээр бүтээх нь нэг насны буян
хэмээн үзэх тул алт, мөнгөөр товойлгон урлахын сацуу
есөн эрдэнээр бичсэн нь цөөнгүй. Ийнхүү судрыг есөн
эрдэнээр бичихдээ шүр, сувд, тана, номин, оюуг бутлан
тусгай аргаар гарган авна. Улмаар зөвхөн гар аргаар
хийсэн гялалзсан хар цаасан дээр эрдэнийн будгаар
бичдэг байна. Ингэхэд сувд нь бор туяатай, номин, оюу
нь цайвар ногоон, цайвар цэнхэр өнгөтэй болдог ажээ.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙГ ТОГТВОРЖУУЛАХ БОДЛОГО, ЗАГВАРЧЛАЛЫН АСУУДАЛ

ДООЖАВЫН ГАН-ОЧИР¹



Монголбанкны Ерөнхий эдийн засагч, Эдийн засгийн ухааны доктор (PhD), Дэд профессор Д. Ган-Очир “Монгол Улсын эдийн засгийг тогтворжуулах бодлого, загварчлалын асуудал” сэдэвт бүтээл туурвиж, Шинжлэх Ухааны Академийн дэргэдэх Эдийн засгийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах Эрдмийн зөвлөлөлийн жинхэнэ хамгаалалтаар түүнд Эдийн засгийн шинжлэх ухааны доктор (ScD)-ын зэрэг олгохыг дэмжсэн байна. Энэхүү бүтээл нь орчин үеийн чиг хандлагад түшиглэн Монгол Улсын эдийн засгийн онцлогийг тусгасан макро эдийн засгийн загваруудыг шинээр боловсруулж, тэдгээрийг өөрийн орны тоон өгөгдлийн хувьд туршин баталгаажуулж, шинэ эмпирик баримтуудыг гаргаж, эдийн засгийг тогтворжуулах, тэнцвэрийг хангах онолын үзэл баримтлал, арга зүйн нэгэн хувилбарыг боловсруулснаараа шинжлэх ухаанд өндөр хувь нэмрийг оруулж буйгаагаар үнэ цэнтэй бүтээл болжээ.

Макро эдийн засгийн тогтвортой байдал нь дангаараа нийгмийн хөгжлийн хангалттай нөхцөл биш хэдий ч тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангах зайлшгүй нөхцөл болдог билээ. Гэвч Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойших 30 жилийн хугацаанд уналт-өрнөлийн цөөнгүй мөчлөгтэй нүүр тулж, түүний хэлбэлзэл нь өндөр зардлыг араасаа дагуулж ирэв. Иймд Монгол Улсын эдийн засгийг тогтворжуулах асуудлын үзэл баримтлал, арга зүйг өөрийн орны онцлогийг тусган боловсруулах хэрэгцээ шаардлага байсаар байна.

Эдийн засаг нь цаг хугацааны туршид байнга хувьсан өөрчлөгддөг, дотоод бүрдэл, элементүүд нь нэгдмэл харилцан уялдаатай бүхэл бүтэн “амьд” бөгөөд “цогц” систем юм. Иймд түүний доторх хувьсагч элементүүдийн хоорондох бүтцийн хамаарал, харилцан үйлчлэлийг бүрэн агуулсан загваруудыг ашиглах нь бодлогын шинжилгээ хийх, тэр дундаа бодлогын арга хэрэгслийн нөлөөг тооцох, олон хувилбарт онолуудын үйлчлэлийг шалгах, эдийн засгийн цаашдын төлөвийн талаар төсөөлөл гаргах, нийгэм, эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд гарч болзошгүй цочрол өөрчлөлтийн нөлөөг урьдчилан тооцох зэрэгт чухал ач холбогдолтой.

¹ Монголбанкны Ерөнхий эдийн засагч, Эдийн засгийн шинжлэх ухааны доктор (ScD), Дэд профессор. Энэ нь түүний Эдийн засгийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан нэг сэдэвт бүтээлийн хураангуй болно. Тус нийтлэлд гарах санаа, дүгнэлт нь Монголбанкны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Энэ бүтээлийн шинжлэх ухаанд оруулж буй хувь нэмэр нь орчин үеийн чиг хандлагад түшиглэн Монгол Улсын эдийн засгийн онцлогийг тусгасан макро эдийн засгийн загваруудыг шинээр боловсруулж, тэдгээрийг өөрийн орны тоон өгөгдлийн хувьд туршин баталгаажуулж, шинэ эмпирик баримтуудыг гаргаж, эдийн засгийг тогтворжуулах, тэнцвэрийг хангах онолын үзэл баримтлал, арга зүйн нэгэн хувилбарыг боловсруулсанд оршино.

Бүтээлийн шинэлэг талыг дараах байдлаар тоймлож болно. Үүнд:

1. Макро эдийн засгийн загварчлал, тогтворжуулах бодлогын онол, арга зүйн чиг хандлагыг системтэй судалж, сүүлийн үеийн чиг хандлагыг Монгол Улсын эдийн засагт нутагшуулан ашиглах боломжид үнэлэлт өгсөн.
2. Монгол Улсын эдийн засгийн онцлогийг судалгаагаар гарган тавьж, зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойших 30 жилийн хугацаанд тохиосон эдийн засгийн мөчлөгүүд, тэдгээрийн шалтгаан, хэрэгжүүлж ирсэн тогтворжуулах бодлогын үр дүнд шинжилгээ хийж, тэдгээрийг эдийн засгийн загваруудад хэрхэн онолын үндэслэлтэйгээр тусгах талаар санал дэвшүүлсэн.
3. Өөрийн орны эдийн засгийн онцлог, баримтуудыг тусгасан харилцан шүтэлцээтэй гурван загварыг шинээр боловсруулж, бодит байдалд хэрхэн нийцэж байгааг статистик, эконометрик аргаар баримтжуулж, эдийн засгийг тогтворжуулах бодлогын шинжилгээнд ашигласан.
4. Эдийн засгийн харилцан шүтэлцээтэй гурван загварын параметруудийг өнөөдөр дэлхий дахинд өргөн ашиглагдах болсон Бейсийн эконометрик аргаар үнэлж, эмпирик шинжилгээг хийсэн. Үүгээрээ Монгол Улсын хувьд эдийн засгийн харилцан шүтэлцээтэй загваруудад суурилсан шинжилгээг Бейсийн эконометрик аргаар дагнан хийсэн анхдагч

бүтээл болсон.

5. Том хэмжээний Бейсийн VAR загвараар эрдэс түүхий эдийн эрэлт, үнэ, ГШХО болон глобал эрэлт зэрэг гадаад хүчин зүйлсийн эдийн засагт үзүүлэх нөлөөг судалсан.
6. Эрдэс түүхий эд экспортлогч орны онцлогийг тусгасан, DSGE-д суурилсан бүтцийн загварыг шинээр боловсруулж, бодлогын нөлөө, шилжих механизмыг судалж, эдийн засгийг тогтворжуулах оновчтой хосолсон бодлогыг тодорхойлсон.
7. Жижиг, нээлттэй, түүхий эд экспортлогч орны Шинэ Кейнсийн GAP загварыг гадаад хүчин зүйлс (эрдэс түүхий эдийн эрэлт, үнэ болон ГШХО)-ээр өргөтгөж шинэ загвар боловсруулж, эдийн засгийн динамик тэнцвэр, мөчлөгийг тооцоолж, түүнд нөлөөлөгч гадаад хүчин зүйлсийг анхлан судалсан.
8. Монгол Улсын эдийн засгийг судлах загвар, арга зүйг шинээр боловсруулах, макро бодлогын хувилбаруудыг гаргаж, хэрэгжүүлэх шинэлэг, баримтад тулгуурласан санал, зөвлөмжийг дэвшүүлсэн.

Энэхүү нэг сэдэвт бүтээлийн үр дүн, дүгнэлтэд суурилан Монгол Улсын эдийн засгийг тогтворжуулах, гадаад хүчин зүйлс, улс төрөөс үл хамаарсан эдийн засгийн тэнцвэрийг хангахад чиглэсэн бодлого, арга зүйн нэгэн хувилбарыг санал болгож байна:

Нэгд, загварын үр дүнгээр Монгол Улсын эдийн засаг тогтвортой хөгжих **макро эдийн засгийн шалгуур үзүүлэлтүүд** нь 1) инфляц 6 хувийн орчимд тогтвортой байх, 2) ДНБ-ий өсөлт жилд 5-6 хувиас (потенциал өсөлтийн түвшнээс) доошгүй байх, 3) богино хугацааны нэрлэсэн хүү нэг оронтой тоонд байх, 4) ажилгүйдлийн түвшин 8 хувиас хэтрэхгүй байх нь тохиромжтой гэсэн үр дүн гарлаа. Өөрөөр хэлбэл, төсөөлөлд суурилсан, дунджаар инфляцыг онилох мөнгөний бодлогын арга хэлбэрийг үр дүнтэй нутагшуулан хэрэгжүүлэх хандлага энэ ажлаар томъёологдсон болно. Энэ нь эдийн засгийг динамик

тэнцвэр дээр хадгалах боломжит нэг хувилбар байх болов уу. Энэ хувилбар нь эдийн засгийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр дотоод хуримтлалыг бий болгох, гадаад хүчин зүйлийн нөлөөллөөс хамааралгүй болох, цаашлаад гадаад өр төлбөрөө төлж, эдийн засаг өөрөө өөрийгөө тэтгээд явдаг болох “том ажил”-ын суурь нөхцөл гэж үзэж байна.

Хоёрт, судалгааны үр дүнг бодлого боловсруулалт, практикт тусгах үүднээс **Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд дараах өөрчлөлт оруулах** саналыг гаргаж байна: 1) Мөнгөний бодлогын үндсэн зорилтыг дотоод үнийн тогтвортой байдлыг хадгалах буюу инфляцын зорилтыг хангах явдал гэж нэгэн утгатай ойлгогдохоор тодорхойлох; 2) Төв банкны зорилт, үйл ажиллагаа нь дан ганц засгийн газраас гадна, улс төрөөс бүрэн хараат бус, бие даасан байх, сонгуулийн мөчлөгөөс ангид байх зохицуулалтыг тодорхой тусгах; 3) Мөнгөний бодлого бусад эдийн засгийн бодлого, зорилттой хэрхэн уялдах зааг ялгааг тодорхой болгох; 4) Төв банкны үйл ажиллагааны үр дүн, хариуцлагыг үндсэн зорилтыг хэрхэн хангаснаар нь дүгнэх механизмыг тодорхой тусгах. Ингэснээр Монголбанк улс төрөөс ангид байж, мэргэжлийн түвшинд эдийн засгийг тогтворжуулах чиг үүргээ бусад төв банкуудын жишгээр хэрэгжүүлэх суурь нөхцөл бүрдэнэ.

Гуравт, эдийн засгийн одоогийн бүтэцтэй, гадаад хүчин зүйлсийн цочрол өөрчлөлтөд өртөх эмзэг байдал өндөртэй орчинд “бодлогын хүү+заавал байлгалх нөөцийн хувь” гэсэн бодлогын сонголт нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг, “бодлогын хүү+өөрийн хөрөнгийн харьцаа” гэсэн сонголт нь санхүүгийн тогтвортой байдлыг дан данд нь бүрдүүлэхэд үр дүнтэй, оновчтой хосолсон бодлогын сонголт байхаар байна. Харин макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг давхар хадгалах чиг үүрэгтэй Монголбанкны хувьд макро эдийн засгийн тогтвортой байдал (инфляц, үйлдвэрлэл болон валютын ханшны тогтвортой байдал)-ын зорилтоо санхүүгийн тогтвортой байдлын зорилтоос хэт өндөр тавихгүй тохиолдолд **мөнгөний бодлогын хүүг ӨХХ-тай хослуулан**

хэрэгжүүлэх нь оновчтой сонголт байх болно. Эдгээр үр дүн нь макро эдийн засгийг санхүүгийн талын загварчлал, шинжилгээнээс гарч ирсэн хэдий ч, санал болгож буй бодлогын үр дүнд эдийн засаг тогтворжиж, дотоод хуримтлал нэмэгдэх нөхцөл бүрдсэнээр эдийн засаг тэнцвэрт байдлаа хадгалах замаар цааш тэлж өргөжих боломж бүрдэх юм.

Дөрөвт, гадаад цочрол өөрчлөлттэй орчинд эдийн засгийг тогтворжуулах зорилгоор төсөв, мөнгөний болон макро зохистой **бодлогын хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ цочрол өөрчлөлтийн шинж чанарыг зайлшгүй харгалзах** нь зүйтэй. Учир нь, эрдэс түүхий эдийн үнийн цочрол өөрчлөлт нь Монгол Улсын эдийн засагт “Голланд өвчин”-ий шинж тэмдгийг түлхүү бий болгох бол, эрдэс түүхий эдийн эрэлт болон ГШХО-ын цочрол өөрчлөлтүүд нь эдийн засагт богино хугацаандаа “хэт халалт”-ыг бий болгохоор байна. Иймд эрдэс түүхий эдийн үнийн цочрол өөрчлөлтөөс үүдэлтэй эдийн засгийн хэлбэлзлийг тогтворжуулахад төсвийн болон макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг ашиглах, харин ГШХО-ын болон эрдэс түүхий эдийн эрэлтийн цочрол өөрчлөлтөд макро зохистой бодлогын хэрэгслээс гадна мөнгөний бодлогын хүүгээр хариу үйлдэл үзүүлэх нь үр дүнтэй байх судалгаа гарсан юм.

Тавд, гадаад хүчин зүйлсийн сөрөг нөлөөг зөөлрүүлэх чиглэлд макро зохистой **бодлогын шинэ хэрэгслүүдийг нэвтрүүлэх** хэрэгцээ, шаардлага өндөр байна. Цаашид бодлогын хэрэгслүүдийн оновчтой хослолыг тодорхойлохдоо дөрөвдүгээр бүлэгт харуулсан эдийн засгийн тогтворгүй байдлаас үүдэх алдагдлын функцэд суурилсан арга зүйг ашиглахыг санал болгож байна. Энэ нь нийт эдийн засгийн тогтвортой байдал (санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдал нэгэн зэрэг)-ыг хангахуйц байдлаар оновчтой хослолыг гаргах боломж олгох юм.

Зургаад, Монгол Улсын эдийн засгийн динамик тэнцвэр нь түр зуурын болон гадаад хүчин зүйлсээс өндөр хамааралтай тул түүний эмзэг байдлын зэргийг бууруулах, дархлааг бэхжүүлэхэд чиглэсэн

макро эдийн засгийн болон бүтцийн бодлого, арга хэмжээг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүний тулд макро болон бүтцийн бодлогын хувьд мөчлөгийн өрнөлийн үед бүх секторт **буфер нөөц бүрдүүлэх (төсвийн орон зай болон гадаад валютын нөөцөө хуримтлуулах буюу мөчлөг сөрсөн бодлого хэрэгжих), дархлааг бэхжүүлэх суурь үзүүлэлтүүдийг дээшлүүлэх, тогтвортой өсөлтийн суурийг бүрдүүлэх, бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх** шаардлага тавигдаж байна. Түүнчлэн дотоод эдийн засгийг гадаад зах зээлээс хамаарал багатай болгох, эдийн засгийг төрөлжүүлэх хүрээнд Аж үйлдвэрийн IV хувьсгалаар бий болсон дижиталчлалыг ашиглан мэдээллийн технологи, инноваци, аялал жуулчлал, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг түлхүү дэмжин хөгжүүлэх шаардлагатай. Төрийн бодлого нь эдгээр салбарын хөгжил, дэвшилд саад тотгор болох бус, харин дотоод салбар дундын уялдаа холбоог хангах, гадаад зах зээлд гарах гүүр болох зэрэгт бодлогын дэмжлэг үзүүлэхийг санал болгож байна.

Долоод, эдийн засгийг төрөлжүүлэх, чанартай ажлын байрыг бий болгоход экспортын чиг баримжаатай аж үйлдвэржилт, бизнес эрхлэгчдийг дэмжих шаардлага зүй ёсоор гарч ирнэ. Үүний тулд манай орны хувьд санхүүжилтийн зардлыг бууруулах хэрэгцээ өндөр байна. Эн тэргүүнд инфляцыг тогтвортой нам түвшинд барих, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, төсвийн сахилга батыг хангасан, хүртээмжтэй өсөлтийг бүрдүүлсэн эдийн засгийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, чанаргүй зээлийг бууруулах эрх зүйн шинэчлэл хийх, санхүүгийн салбарт сайн засаглалыг бүрдүүлэх, санхүүгийн зуучлал хэвийн явагдахад шаардлагатай санхүүгийн зохицуулалтын бодлогыг тууштай баримтлах шаардлагатай. Хямд өртөгтэй санхүүжилтийн механизмууд бүрдсэнээр экспортын чиг баримжаатай боловсруулах үйлдвэрлэл хөгжиж, төлбөрийн тэнцэл сайжрахын хэрээр дотоод санхүүгийн хуримтлал нэмэгдэнэ. Энэ нь эдийн засаг дотоод эх үүсвэрээрээ өөрийгөө тэтгэх хуримтлалтай болох, улмаар тогтвортой эдийн засгийн өсөлт,

хөгжилд хүрэх суурь орчин болох юм.

Наймд, Монгол Улсын хөгжлийн гол тулгуур нь хүний хөгжил, хөдөлмөр эрхлэлт билээ. Энэ утгаараа хүндээ, оюундаа хөрөнгө оруулалт хийх, хүний нөөц ашиглалтыг сайжруулах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, түүнийг даган хөдөлмөрийн үнэлэмжийг өсгөх шаардлагатай. Энэ нь эргээд иргэдийн амьжиргааг дээшлүүлж, дотоод хуримтлалыг бүрдүүлнэ. Иймд төрөөс хэрэгжүүлэх эдийн засгийн бодлого нь 'хүн төвтэй', хүний хөгжлийг дэмжсэн, чанартай ажлыг байрыг бий болгоход эн тэргүүнд чиглэх шаардлагатай байна.

Ест, Макро эдийн засгийн нэгдсэн цогц бодлогын тогтолцоог манай оронд нутагшуулан ашиглах нь төрийн эдийн засгийн бодлогын уялдааг хангах, бодлогын хэрэгслүүдийн сонголтыг ойлгомжтой болгох тохиолдолд л эдийн засгийг тогтворжуулахад бодит үр дүн өгнө. Өөрөөр хэлбэл, сангийн, мөнгөний, макро зохистой бодлогын, гадаад валютын интервенцийн, хөрөнгийн урсгалын удирдлагын бодлогын хэрэгслүүдийн үр нөлөөнд тулгуурлан эдгээр бодлогын уялдаа, оновчтой хослолыг хангах тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.

Аравт, нэгдсэн цогц бодлогын нэг бүрдэл болох хөрөнгийн урсгалын удирдлагын хувьд Монгол Улсад бодлогын хэрэгсэл шинээр нэвтрүүлэх шаардлага гарлаа. Энэ хүрээнд 1981 оны эдийн засгийн Нобелийн шагналт Жемес Тобины санал болгосон Тобин татварыг өөрийн орны онцлогт тохируулах нэвтрүүлж ашиглах боломжтой юм.

Арван нэгд, эдийн засгийн нэгдсэн цогц бодлогын хүрээнд хүний, нийгмийн, эдийн засгийн хөгжлийн зорилтуудыг хангахад бүтцийн, сангийн, мөнгөний бодлогын гүйцэтгэх үүрэг, харилцан уялдааг тодорхой болгох хэрэгцээ шаардлага бодитойгоор бий боллоо. Иймд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бусад холбогдох хуульд улсын төсөв, хөгжлийн бодлогын хоорондын уялдаа хангах, бодлого боловсруулалт, хэрэгжилт, хяналтын механизмыг тодорхой болгох нь зүйтэй.

Арван хоёрт, нэгдсэн цогц бодлогын тогтолцооны хүрээнд **сангийн, мөнгөний, макро зохистой бодлогын гадаад валютын интервенцийн, хөрөнгийн урсгалын удирдлагын хэрэгслүүдийн оновчтой хослолыг тодорхойлсон платформ бий болгох** нь чухал гэж үзэж байна. Үүний тулд юуны өмнө энэ бүтээлд тусган боловсруулсан загвар, аргачлалыг ашиглахыг санал болгож байна. Ялангуяа, гадаад хүчин зүйлсийн дотоод эдийн засагт үзүүлэх нөлөө өндөр байгаа өнөөгийн орчинд сангийн бодлого, тэр дундаа экспорт, импортын татвар, тарифын хувь хэмжээг бодлогын хэрэгслээр ашиглах боломж, үр нөлөөг тооцох нь нэн чухал байгаа тул цаашдын судалгаа, шинжилгээ үүн дээр төвлөрөх шаардлагатай.

Арван гуравт, манай орны хувьд эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийг хангахад оновчтой эдийн засгийн бодлого, тогтвортой төлөвлөлт, үр дүнтэй хэрэгжилтээс гадна сайн засаглал, улс төрийн болон эдийн засгийн институцийг бэхжүүлэх асуудал туйлаас чухал байна. **Зах зээлийн гажуудлыг засахад төрийн зохицуулалт чухал хэдий ч төрийн гажуудлыг "тушихад" сайн засаглал, институци зайлшгүй юм.** Сайн засаглал, институц төлөвшиж байж л эдийн засгийн бодлого нь улс төрийн хараат бус байж, дарамт, шахалтгүйгээр мөчлөг сөрсөн, ирээдүйд чиглэсэн, нэгдсэн цогц хэлбэрээр үр дүнтэй хэрэгжиж, эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжилд хөтлөх юм. Энэ хүрээнд сангийн, мөнгөний, макро зохистой бодлогын болон бүтцийн бодлогын зорилтыг тодорхой болгож, үр дүнд суурилан хяналт тавих, хариуцлага ноогдуулах тогтолцоог цогцоор нь бүрдүүлэх шаардлагатай.

Арван дөрөвт, Монгол Улсын онцлогийг тусгасан макро эдийн засгийн **загвар боловсруулж, мөчлөгийн болон бодлогын шинжилгээ хийх, төсөөлөл гаргахад энэхүү нэгэн сэдэвт бүтээлийн**

эмпирик баримтуудыг зайлшгүй харгалзан тусгах шаардлагатай. Тухайлбал, эдийн засгийн тэнцвэрийн болон мөчлөгийн динамик (тэнцвэрт хүү, үйлдвэрлэлийн зөрүү, потенциал өсөлт болон тэнцвэрт валютын ханш)-ийг тогтмол тооцож, бодлогын шинжилгээ хийхдээ гадаад хүчин зүйлс (эрдэс түүхий эдийн экспортын эрэлт, эрдэс түүхий эдийн үнэ, ГШХО болон БНХАУ-ын өсөлт)-ийн нөлөөг зайлшгүй тусгах нь зүйтэй. Энд боловсруулсан загварыг мөчлөгийн болон тэнцвэрийн динамик цувааг харилцан нийцтэй, хамтад нь тооцох, эдийн засгийг тогтворжуулах бодлогыг оновчтой тодорхойлох нэгдсэн арга зүй, бодлогын шинжилгээ, төсөөллийн системийн нэг бүрдэл хэсэг болгон ашиглах боломжтой.

Энэхүү нэг сэдэвт бүтээлд боловсруулсан Монгол Улсын макро эдийн засгийн гурван загварыг тогтмол давтамжтай үнэлж, бодлогын шинжилгээ, эдийн засгийн дунд хугацааны төсөөлөл гаргахад ашиглахыг санал болгож байна. **Эдгээр загвар, шинжилгээ нь бүрэн автоматжиж, ашиглахад хялбар, олон нийтэд нээлттэй горимд боловсруулагдсан тул бодлого боловсруулагчид, судлаачид үргэлжлүүлэн ашиглах боломжтой юм.** Ялангуяа, эдийн засгийн мөчлөгийг хэмжих, түүний өөрчлөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийг таних, бодлогын нөлөөг тооцох, эдийн засгийн дунд хугацааны төсөөлөл гаргах, бодлогын оновчтой хослол тодорхойлох зэрэгт энд боловсруулсан арга зүйг практикт ашиглах нь чухал байна.

1966 оны 100 төгрөгийн тухай

1960 онд баталсан БНМАУ-ын Үндсэн хуулиар төрийн сүлдийг шинэчилсэн. Иймээс шинэ мөнгөн тэмдэгт гаргахаар болж, эх загварыг Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн, зураач Д.Цэрэнпил, зураач Ц.Минжүүр нар зурж, улмаар ЗХУ-д захиалан, Москва хотын "ГОЗНАК" хэвлэлийн үйлдвэрт хийлгэжээ. 1966 оны мөнгөн тэмдэгт нь 1, 3, 5, 10, 25, 50, 100 төгрөгийн дэвсгэртэй гарсан байна.

Зураг 1. 1966 оны 100 төгрөгийн бодит зураг /хэмжээ: 150 x 65 мм/



ЦАГААН МӨНГӨӨР ХИЙСЭН "ДУРСГАЛЫН ЯЛТСАН ДЭВСГЭРТ" -ИЙН ЗАГВАР:

Дурсгалын ялтсан дэвсгэрт нь 1966 оны 100 төгрөгийн мөнгөн тэмдэгт, 2021 онд тохиох Ардын хувьсгалын 100 жилийн ойн логог ашиглан хийсэн.

"Дурсгалын ялтсан дэвсгэрт"-ийн үзүүлэлт:

- | | |
|-------------------|--------------------------------|
| 1. Үйлдвэрлэх он: | 2021 |
| 2. Нэрлэсэн үнэ: | 100 төгрөг |
| 3. Металл: | Ялтсан мөнгө |
| 4. Жин: | 5 грамм |
| 5. Диаметр: | 150 x 65 мм |
| 6. Чанар: | proof like |
| 7. Технологи: | хэсэгчилсэн өнгөтэй, ламинатор |



Санхүүгийн мэдээллийн албаны дарга
Б.Батбаатартай ярилцлаа.

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР МОНГОЛ УЛС ФАТФ-ЫН ЗӨВЛӨМЖИЙН ҮНЭЛГЭЭГ АХИУЛЛАА

МОНГОЛ УЛСЫН ХУВЬД ФАТФ-ЫН 40 ЗӨВЛӨМЖИЙН ТЕХНИК ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ ЯМАР БАЙДАЛТАЙ БАЙГАА ВЭ?

- Монгол Улс Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага болох ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу "Саарал" жагсаалтаас 2020 оны 10 дугаар сард гарсан. Хэдий тийм боловч манай улс ФАТФ-аас гаргасан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт 40 Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах үүрэг хүлээсэн хэвээр байгаа.

Санхүүгийн мэдээллийн алба нь төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны гадаад, дотоод харилцаа гээд бүхий л асуудлыг хариуцаж ажилладаг. Одоогийн байдлаар Санхүүгийн мэдээллийн албаны дэргэд төрийн 20 гаруй байгууллагын оролцоотой Хамтын ажиллагааны

зөвлөл ажиллаж байна. Мөн цаашдын бодлого, стратегийг тодорхойлох чиг үүрэгтэй Үндэсний зөвлөл бий. Санхүүгийн мэдээллийн албанаас ФАТФ-ын зөвлөмжүүд, бусад стандарттай холбоотой хийгдэх ажлуудыг тухайн бүрд нь эдгээр зөвлөлдөө танилцуулж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд жил бүр Монгол Улсын Явцын тайланг боловсруулан ФАТФ-ын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлж, тогтмол хийсэн ажлуудаа тайлагнадаг. Үүний үр дүнд 2019 онд 15 Зөвлөмж, 2020 онд 3 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээг дийлэнхийг болон бүрэн биелүүлсэн үнэлгээтэй болгож ахиулсан.

Харин 2021 онд үнэлгээг ахиулах ажлыг Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлд тэргүүлэх зорилт болгон оруулснаас гадна "ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө"-г Санхүүгийн мэдээллийн албанаас

боловсруулан, 2020 оны 5 дугаар сард Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан. Ингээд төлөвлөгөөний хэрэгжилтийн дагуу Монгол Улсын Явцын тайланг ФАТФ-ын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт 2021 оны 02 дугаар сард хүргүүлсэн. Улмаар тус бүлгийн Харилцан үнэлгээний хорооны 2021 оны 7 дугаар сард болсон хурлаар Монгол Улсын тайланг хэлэлцэж баталлаа. Ингэхдээ Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлуудыг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа гэж үзэн, ФАТФ-ын Зөвлөмж 1-ийн үнэлгээг “Дийлэнхийг биелүүлсэн” болгож ахиулсан. Үүний үр дүнд Монгол Улс ФАТФ-ын нийт 40 Зөвлөмжөөс 38 Зөвлөмжийг дийлэнхийг болон бүрэн биелүүлсэн үнэлгээ аваад байна.

ФАТФ-аас 2021 оны 9 дүгээр сарын байдлаар нийт 116 улс оронд үнэлгээ хийснээс 4 улс бүх 40 Зөвлөмжийг хангалттай биелүүлсэн үнэлгээтэй байна. Харин 5 улс 39 Зөвлөмжийг, 11 улс 38 Зөвлөмжийг хангалттай биелүүлсэн үнэлгээ авчээ. Монгол Улсыг ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн хувьд бусад улс орнуудтай харьцуулбал 38 Зөвлөмжийг хангалттай биелүүлсэн үнэлгээгээр 18 дугаар байрт орохоор байгаа юм. Энэхүү үнэлгээ нь сүүлийн жилүүдэд Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг хамтран авч хэрэгжүүлсэнтэй холбоотой.

АЗИ, НОМХОН ДАЛАЙН МӨНГӨ УГААХТАЙ ТЭМЦЭХ БҮЛЭГТ МОНГОЛ УЛСЫН ЯВЦЫН ТАЙЛАНГИЙН ХҮРЭЭНД ЯМАР АЖЛУУДЫН ТАЛААР ТАЙЛАГНАСАН БЭ?

- Монгол Улсын 2021 оны Явцын тайланд хагас биелэлттэй байсан Зөвлөмж 1, 8, 15 гэсэн 3 зөвлөмжийн үнэлгээг ахиулах зорилгоор нийт 29 шалгуур үзүүлэлтийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тусгасан. Тухайлбал, Зөвлөмж 1 дээр эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх, Зөвлөмж 8-ын хүрээнд ашгийн бус байгууллагыг терроризмыг

санхүүжүүлэхэд ашиглахаас сэргийлэх, Зөвлөмж 15-т виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зохицуулалтын орчинг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тайлагнасан. Тайланг 2021 оны 02 дугаар сард хүргүүлснээс хойш 5 сарын хугацаанд ФАТФ-ын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн үнэлгээний багаас ирүүлсэн хүсэлтийн дагуу нийт 5 удаа нэмэлт тайлбар мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанаас тухай бүр хүргүүлж ажилласан. Мөн 2021 оны 5 дугаар сард үнэлгээний багтай цахим уулзалт хийж, тайлантай холбоотой асуудлуудыг хэлэлцсэн.

ЗӨВЛӨМЖ 1-ИЙН ҮНЭЛГЭЭГ АХИУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДАЙ ХЭРХЭН ХАМТРАН АЖИЛЛАСАН БЭ?

- Зөвлөмж 1-ийн хүрээнд улс орнуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэхийг шаарддаг. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас санаачлан 2020 онд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх ажлыг эхлүүлсэн. Үүний дагуу Сангийн сайдын тушаалаар төр, хувийн хэвшлийн 128 төлөөллөөс бүрдсэн нийт 10 дэд ажлын хэсэг байгуулагдаж, банк, үнэт цаас, даатгал зэрэг салбар тус бүрийн эрсдэлийг Дэлхийн банкны аргачлалын дагуу үнэлсэн. Түүнчлэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А-31 тоот тушаалаар “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, бага эрсдэлтэй харилцагчийг хялбаршуулсан байдлаар таньж мэдэх боломжтой болсон. Иймд Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсыг эрсдэлд суурилсан аргачлалыг үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллаж байгаатай холбоотойгоор ФАТФ-ын Зөвлөмж 1-ийн үнэлгээг ахиулахаар шийдвэрлэсэн. Зөвлөмж 1-ийн шалгуурын дагуу тайланг боловсруулж хүргүүлэхэд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон

Терроризмтой тэмцэх зөвлөлийн Ажлын албанаас ихээхэн үүрэг оролцоотой хамтран ажилласан. Мөн Зөвлөмж 1-ийн хэрэгжилтийг хангахад Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллага тус бүрийн хүчин чармайлт, ажлын уялдаа холбоо чухал ач холбогдолтой байсныг энд онцлон хэлмээр байна.

**- АЗИ, НОМХОН ДАЛАЙН МӨНГӨ
УГААХТАЙ ТЭМЦЭХ БҮЛГЭЭС ФАТФ-ЫН
ЗӨВЛӨМЖҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ
ХОЛБООТОЙ ЯМАР САНАЛ ДҮГНЭЛТ ӨГСӨН
БЭ?**

- Монгол Улс ФАТФ-ын 40 Зөвлөмжөөс нийт 38 зөвлөмжийг техник хэрэгжилтийн хувьд дийлэнхийг болон бүрэн биелүүлсэн бөгөөд Зөвлөмж 8, 15 гэсэн 2 Зөвлөмж хагас биелүүлсэн гэсэн үнэлгээтэй хэвээр байгаа. Үүнтэй холбоотойгоор ФАТФ-ын бүлгээс эдгээр зөвлөмжийн дагуу ашгийн бус байгууллага болон виртуал хөрөнгийн салбарын хууль, эрх зүйн зохицуулалтын орчинг бүрдүүлж ажиллахыг үүрэг болгосон. Тухайлбал, Зөвлөмж 8-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой авч хэрэгжүүлсэн ажлуудаас дурдвал Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ахалсан ажлын хэсэг ашгийн бус байгууллагын салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Түүнчлэн Холбооны эрх зүйн байдлын тухай болон Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдийг Зөвлөмж 8-ын шалгуурт нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барьсан. Мөн Хууль зүй, дотоод хэргийн яам, Терроризмтой тэмцэх зөвлөлийн Ажлын албанаас НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран соён гэгээрүүлэх сургалтуудыг зохион байгуулсан. Үүнээс гадна ашгийн бус байгууллагуудыг ашиглан терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой мөрдөн шалгах ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр Тагнуулын ерөнхий газраас холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн талаар тайлагнасан. Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Зөвлөмж 8-ын хүрээнд ашгийн бус байгууллагын салбарт мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх

эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх, хууль, эрх зүйн орчныг сайжруулахыг үүрэг болгож, үнэлгээг нэмэгдүүлэхгүй хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн.

**- МОНГОЛ УЛСАД ВИРТУАЛ ХӨРӨНГӨ,
КРИПТОВАЛЮТЫН ЗОХИЦУУЛАЛТЫГ
БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЯМАР АРГА
ХЭМЖЭЭГ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА ВЭ?**

- ФАТФ-ын Зөвлөмж 15-ын дагуу улс орнууд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд хамруулж, зохицуулалтын орчинг бүрдүүлэх үүрэгтэй. Энэ хүрээнд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг Санхүүгийн мэдээллийн албанаас ахлан Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, хууль сахиулах байгууллагуудтай хамтран хийж, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлсэн. Тус бүлгээс Монгол Улсад виртуал хөрөнгийн салбарын зохицуулалтын орчинг бодитоор бий болгож хэрэгжүүлэхийг үүрэг болгосон. Иймд Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хамтран Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг ФАТФ-ын шаардлага болон олон улсын туршлагад нийцүүлсэн боловсруулсан. Хуулийн төслийг олон нийтэд нээлттэй хэлэлцүүлж, Хамтын ажиллагааны зөвлөл, Засгийн газрын гишүүд, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын саналыг авсан. Хуулийн төсөлтэй холбоотойгоор нийт дагалдах 10 хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар болсон байгаа. Хуулийн төслийг 2021 оны 5 дугаар сард Улсын Их Хуралд өргөн барьсан бөгөөд 2021 оны намрын чуулганаар хэлэлцүүлж, батлуулахаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Хууль батлагдсанаар виртуал хөрөнгөтэй холбоотой хууль, эрх зүйн орчин бүрдэхээс гадна ФАТФ-ын зөвлөмжийг биелүүлэх, эдийн засгийн эргэлт нэмэгдэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах эерэг нөлөөтэй.

**- ЦААШИД ФАТФ-ЫН 40 ЗӨВЛӨМЖИЙГ ҮР
ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЯМАР
АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛАХ ВЭ?**

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн 2021 оны 9 дүгээр сарын ээлжит хурлаар энэ асуудлыг Санхүүгийн мэдээллийн албанаас танилцуулж хэлэлцүүлсэн. Үүний дүнд Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар "ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө"-г шинэчлэн баталсан. Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах замаар хагас биелэлттэй байгаа Зөвлөмж 8, 15-ын үнэлгээг ахиулах бүрэн боломжтой болох юм. Ингэснээр Монгол Улс ФАТФ-ын бүх 40 Зөвлөмжийг техник хэрэгжилтийн хувьд хангалттай биелүүлсэн үнэлгээг авах ач холбогдолтой. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагуудтай хамтран Монгол Улсын 5 дахь шатны Явцын тайланг боловсруулж, 2022 оны 02 дугаар сард ФАТФ-ын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлэх болно.

Түүнчлэн Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийг боловсруулахдаа ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээг сайжруулахтай холбоотой ажлуудыг тусгахад анхаарч байна. Үндэсний хөтөлбөр болон түүний хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлж, Засгийн газар болон Улсын Их Хурлаар батлуулах болно. Энэхүү Үндэсний хөтөлбөр нь ФАТФ-аас Монгол Улсад 2023 онд хийх Харилцан үнэлгээний бэлтгэл ажлын суурь болох бөгөөд ФАТФ-ын 40 зөвлөмжийн техник хэрэгжилт болон Шууд хэрэгжилтийн 11 шалгуур үзүүлэлтийн үнэлгээг амжилттай ахиулах үндэс болно.

- Ярилцсанд баярлалаа.



2021 ОНД БОДЛОГЫН ХҮҮГЭЭ ӨСГӨСӨН ТӨВ БАНКУУД

Б.БАТМАНДАХ¹, Г.МӨНХБАЯР²

КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор төв банкууд бодлогын хүүгээ бууруулж, мөнгөний бодлогоо зөөлрүүлж байв. Харин 2021 оны эхэн үеэс зарим улсын төв банкууд мөнгөний бодлогоо чангаруулж эхэллээ. Тухайлбал, Мозамбик улсын төв банк 2021 оны 1 дүгээр сарын 27-ны мөнгөний бодлогын хорооны хурлаараа бодлогын хүүгээ 3 нэгж хувиар өсгөж 13.25 хувьд хүргэснээр 2021 онд бодлогын хүүгээ өсгөсөн **анхны** төв банк болов. 2021 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн байдлаар энэ онд нийт **31** улсын төв банк 56 удаа бодлогын хүүгээ өөрчлөх шийдвэр гаргасан байна. Үүнээс 48 удаагийн шийдвэрээр

бодлогын хүүг өсгөсөн бол 8 удаа бууруулав. Түүнчлэн одоогоор бодлогын хүүгээ өөрчлөөд буй **31** улсын төв банкны бодлогын хүүний 2021 оны нийт өөрчлөлтийг авч үзвэл 0.5 хүртэл нэгж хувиар хүүгээ өсгөсөн 10 төв банк байгаа бол 1.5-2.5 нэгж хувиар хүүгээ нэмэгдүүлсэн 8 улс байна (Зураг 1). Орлогын ангиллаар авч үзвэл бага орлоготой улсуудын хувьд бодлогын хүүг харьцангуй ихээр нэмэгдүүлсэн бол дундаас дээгүүр болон өндөр орлоготой улсуудын төв банк бодлогын хүүгээ харьцангуй багаар өсгөх хандлага ажиглагдав. Бодлогын хүүгээ өсгөсөн улсуудаас дурдвал **1) Бага болон дундаас доогуур**


¹ Мөнгөний бодлогын газрын Мөнгөний бодлогын төсөөллийн хэлтсийн эдийн засагч

² Мөнгөний бодлогын газрын Мөнгөний бодлогын төсөөллийн хэлтсийн эдийн засагч

орлоготой – Мозамбик, Замби, Киргиз, Тажикстан, **2) Дундаас дээгүүр орлоготой** - Гүрж, Бразил, Армен, Мексик, Беларусь, Орос, Молдав, Казахстан,

Перу, Парагвай, **3) Өндөр орлоготой**- Исланд, Чех, Унгар, Чили, Уругвай, Солонгос зэрэг улсууд бодлогын хүүгээ 2021 онд өсгөөд байна.

Зураг 1. 2021 онд бодлогын хүүгээ өөрчилсөн улсуудын тоо




Эх сурвалж: CentralBankRates

Бодлогын хүүгээ өсгөсөн улсуудын мөнгөний бодлогын мэдэгдэлд дараах голлох үндэслэл, шалтгаануудыг дурдсан байна.

- Инфляц зорилтот түвшнээс давж өссөн бөгөөд цаашид ч өсөхөөр хүлээлттэй байна (Зураг 2). Хэдийгээр дийлэнх улсад нийлүүлэлтийн шинжтэй инфляцын нөлөө голлож байгаа ч вакцинжуулалт эхэлж, КОВИД-19 цар тахалтай холбоотой хөл хориог сулруулснаар дотоод эдийн засгийн идэвхжил сэргэж эрэлтийн шинжтэй инфляцыг өдөөж байгаа нь мөнгөний бодлогыг чангаруулах шалтгаан болов.
- Дэлхийн эдийн засгийн сэргэлт болон зарим нийлүүлэлтийн шалтгаантай холбоотой дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ, хүнсний үнийн өсөлт нь улс орнуудад инфляцыг нэмэгдүүлж байна.
- Инфляц өндөр түвшинд удаан хадгалагдах нь инфляцын хүлээлтийг нэмэгдүүлэх эрсдэлтэй байгааг дурдав.
- Зарим улсуудад нийлүүлэлтийн шалтгаантай инфляцаас гадна валютын ханш сулрах дам нөлөөгөөр инфляц нэмэгдэж байгаа нь тулгамдсан асуудал болж байна.
- Зарим улсуудад хэдийгээр эдийн засгийн идэвхжилтэй уялдан хөдөлмөрийн эрэлт сэргэж байгаа боловч цар тахалтай холбоотойгоор хөдөлмөрийн нийлүүлэлт төдийлөн нэмэгдэхгүй байгаагаас шалтгаалж цалин өсч, инфляцад нөлөөлж байна.
- Цаашид цар тахалтай холбоотой үүссэн нийлүүлэлтийн шинжтэй инфляц хэзээ буурах нь тодорхой бус байна. Улмаар төсөөллийн хугацаанд эрэлтийн шинжтэй инфляцаас гадна нийлүүлэлтийн шинжтэй инфляц өндөр түвшинд хадгалагдаж, инфляц үргэлжлэн нэмэгдэх эрсдэлтэй (upside risk) байна.

Зураг 2. Инфляцын гүйцэтгэлийн инфляцын зорилтоос зөрөх зөрүү¹



Зарим улсын төв банкны бодлогын хүүний талаарх шийдвэр, түүний үндэслэлийг улс тус бүрээр авч үзлээ.

1) КАЗАХСТАНЫ ТӨВ БАНК

Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 7 дугаар сарын хурлаар бодлогын хүүг 0.25 нэгж хувиар нэмэгдүүлж 9.25 хувьд хүргэв. Бодлогын шийдвэрт дараах хүчин зүйлс голлон нөлөөлжээ.

- Энэ оны 6 дугаар сарын эцэст инфляц 7.9 хувьд хүрч, зорилтот түвшин (4-6%)-ээс өндөр хэвээр байна. Инфляц нэмэгдэхэд хүнсний инфляц голлох нөлөө үзүүлсэн ба шатахуун болон эрэлтийн шинжтэй инфляц мөн нэмэгдүүлэх нөлөөтэй байв. Инфляц нэмэгдэж, зорилтот түвшнээс өндөр байгаатай холбоотой олон нийтийн инфляцын хүлээлт тогтворгүй байна.
- Эдийн засгийн идэвхжил үргэлжлэн сэргэж байна. Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн өсөлт болон хөл хориог сулруулсан нөлөөгөөр

эдийн засгийн голлох салбарууд сэргэж байгааг онцлов. Ийнхүү хөл хориог сулруулж, эдийн засгийн идэвхжил нэмэгдэж байгаа нь эрэлтийн шинжтэй инфляцыг өдөөх хүлээлттэй байна. Үүнд хэрэглээ огцом нэмэгдэх болон төсвийн төлөв үргэлжлэн сулрах хүлээлттэй байгаа нь голлох нөлөөг үзүүлнэ.

- Цаашид цар тахлын нөхцөл байдалтай холбоотой дэлхийн зах зээл дээр хүнсний үнийн өсөлт, нийлүүлэлтийн сүлжээ доголдох зэрэг нь голлох худалдааны түнш улсуудын инфляцыг нэмэгдүүлэх дам нөлөөгөөр инфляцыг өсгөх эрсдэлтэй байна. Олон улсын туршлагаас үзвэл мөнгөний бодлогоор нийлүүлэлтийн шинжтэй инфляцад нөлөөлж чадахгүй, харин энэхүү бодлогын шийдвэрээр эрэлтийн шинжтэй инфляцад хариу үйлдэл үзүүлж байгааг онцлов. Улмаар хүлээгдэж буй инфляц 2021 оны турш зорилтот түвшин (4-6%)-ээс өндөр байх болон бодлогын хүүний өөрчлөлтийн эдийн

¹ Эдгээр 11 улсын хувьд инфляцын гүйцэтгэлийн инфляцын зорилтоос зөрөх зөрүүг (Инфляц – инфляцын зорилт) тооцож, хамгийн их зөрүүтэй байгаа 5 улсыг зүүн гар талын зурагт харуулав.

засагт үзүүлэх нөлөөллийг харгалзан үзээд бодлогын хүүг өсгөх шийдвэр гаргав. Цаашид шаардлагатай бол шат дараатай бодлогын тохируулга хийж 2022 оны эхэнд инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулна.

2) СОЛОНГОСЫН ТӨВ БАНК

Солонгосын төв банк 2021 оны 8 сарын 26-ны өдрийн ээлжит мөнгөний бодлогын хорооны хурлаар бодлогын хүүгээ 0.25 нэгж хувиар нэмэгдүүлж 0.75 хувьд хүргэсэн нь 2018 оны 9 сараас хойш анх удаа бодлогын хүүгээ өсгөсөн шийдвэр байлаа. Ингэснээр Азийн томоохон төв банкуудаас цар тахлын үед бодлогын төлөвөө өөрчилсөн анхдагч төв банк болов. Бодлогын шийдвэрт дараах хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна.

- Эдийн засгийн идэвхжил алгуур сэргэж байна. Хэдийгээр КОВИД-19 вирусийн тархалт нэмэгдэж хувийн хэрэглээний өсөлт саарсан ч экспортын орлого болон хөрөнгө оруулалтын өсөлт өндөр түвшинд хадгалагдав. Түүнчлэн хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал үргэлжлэн сайжирч, ажил эрхлэлт өмнөх жилийн мөн үеэс нэмэгдлээ. Цаашид вакцинжуулалт эрчимжиж, төсвийн тодотголоор нэмэлт зардал батлагдсанаар хувийн хэрэглээ аажмаар сэргэн эдийн засгийн өсөлтийг дэмжих хүлээлттэй байна.
- Инфляц зорилтот түвшин (2%)-ийг давж 2.6 хувь орчимд хүрэв. Ийнхүү инфляц нэмэгдэхэд шатахуун, бүх төрлийн мах, махан бүтээгдэхүүн, ХАА-н бүтээгдэхүүн болон үйлчилгээний салбарын үнийн өсөлт голлон нөлөөлжээ. Түүнчлэн олон нийтийн инфляцын хүлээлт 2.5 хувь болж нэмэгдлээ.
- Гадаад хөрөнгийн зах зээл болон КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр дотоодын санхүүгийн зах зээлд хувьцааны үнүүд буурч, воны ам.доллартай харьцах ханш суларч байна.
- Иргэдийн зээлийн үлдэгдэл болон орон сууцны үнэ огцом өсч байна. Түүнчлэн эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хүрээнд жижиг дунд үйлдвэрлэгч ААН-үүдэд олгосон зээлийн

үлдэгдэл мөн өсч байна. Ийнхүү эдийн засгийн өсөлт алгуур сэргэх, инфляц богино хугацаанд зорилтот түвшнээс давахаар хүлээлттэй байна. Дээр дурдсан хүчин зүйлсийг харгалзан үзээд эдийн засгийн сэргэлтийг хадгалах, инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах бодлогын шийдвэр гаргав.

3) УНГАРЫН ТӨВ БАНК

Бодлогын хүүг 2021 оны 6, 7 болон 8 дугаар саруудад тус тус 0.3 нэгж хувиар буюу нийт 0.9 нэгж хувиар өсгөж 1.5 хувьд хүргэлээ. Бодлогын шийдвэрийн үндэслэлийг авч үзвэл:

- Вакцинжуулалтын хувь харьцангуй сайн буюу Евро бүсд хамгийн өндөр байгаа нь бусад Европын холбооны улсуудаас эрт хөл хориог сулруулж, эдийн засгаа нээхэд нөлөөлөв. Улмаар эдийн засгийн өсөлт төсөөллөөс өндөр байгааг онцоллоо. Тодруулбал, 2021 оны 2 дугаар улирлын ДНБ-ний өсөлт 17.9 хувьд хүрэв. Хэдийгээр эдийн засгийн өсөлт сэргэж байгаа ч салбаруудын сэргэлтийн хурд жигд бус байна. Цар тахлаас үүдэж зогсонги байдалд орсон эдийн засгийг шат дараатай нээх, хөл хорионы дэглэмийг сулруулах нөлөөгөөр эдийн засгийн идэвхжил 2021 оны 3 дугаар улиралд хямралын өмнөх үеийн түвшинд хүрэхээр байна. Салбаруудаас боловсруулах салбарын хурдацтай өсөлтийг даган барилга болон худалдааны салбарын өсөлт эрчимжиж эхэлсэн бол цар тахалд хамгийн их өртсөн үйлчилгээний салбарын идэвхжил төдийлөн сэргэхээргүй байна.
- Эдийн засгийн идэвхжилтэй уялдан хөдөлмөрийн зах зээл хүлээлтээс хурдацтай сэргэж байна. Ажилгүйдлийн түвшин 2021 оны 2 дугаар улирлаас эхлэн буурч энэ оны 2 дугаар хагаст 4 хувиас доогуур түвшинд хүрэх хүлээлттэй. Гэсэн хэдий ч цар тахлаас үүдэлтэй хөдөлмөрийн нийлүүлэлт харьцангуй хөшүүн байгаагаас шалтгаалан зарим салбаруудад эрэлт, нийлүүлэлтийн зөрүү үүсч байна.

- Энэ онд төсвийн тодотголоор төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийг 2.9 хувиас 7.5 хувь болгон нэмэгдүүлэв. Харин ирэх жилүүдээс эдийн засгийн идэвхжилтэй уялдан төсвийн орлого бүрдүүлэлт нэмэгдэх, цар тахалтай холбоотой нэмэгдээд байсан төсвийн зардлууд буурах нөлөөгөөр төсвийн төлөв чангарах хүлээлттэй байна.
- Эдийн засгийн идэвхжил сэргэхтэй холбоотой инфляцын дарамт нэмэгдэж 2021 онд төв банкны зорилтот түвшин ($3\pm1\%$)-ээс өндөр байх хүлээлттэй байна. Ийнхүү эдийн засгийн сэргэлттэй уялдан мөнгөний бодлогыг чангаруулах бодлогын арга хэмжээ авч 2022 оны эхнээс инфляц зорилтот түвшин ($3\pm1\%$)-д тогтворжих хүлээлттэй байна.
- Энэ оны инфляцын хүлээлт үргэлжлэн нэмэгдэв. Хэдийгээр инфляцыг голлон нэмэгдүүлж байгаа шокууд нь түр зуурийн шинжтэй боловч эдгээр нь үнэ тогтох процесс (price formation process)-д сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Түүнчлэн инфляцыг нэмэгдүүлсэн нийлүүлэлтийн шокууд нь төсөөллийн хугацаанд хадгалагдах, цар хүрээгээ тэлэх зэргээс шалтгаалан үнийн түвшинг өсгөх эрсдэлтэй (upside-risk) байна.
- 2021 оны 2 дугаар улиралд эдийн засаг үргэлжлэн сэргэв. Хувийн хэрэглээний өсөлт 2020 оны эцсээс огцом нэмэгдсэн хэдий ч хямралын өмнөх үеийн түвшинд хараахан хүрээгүй байна. Харин хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд 2021 оны 2 дугаар улирлаас эхлэн сайжирч байна. Улсын хэмжээнд ажилгүйдэл оны эхнээс буурч байгаа ч хөдөлмөрийн зах зээл бүрэн сэргээгүй байгааг онцлов.

4) МЕКСИКИЙН ТӨВ БАНК

Дэлхийн улс орнуудын эдийн засгийн идэвхжил нь вакцины хүртээмж, цар тахлын тархалт, эдийн засгийг сэргээх хөтөлбөр зэргээс шалтгаалан сэргэлт жигд бус байна. Түүхий эдийн үнийн дарамт, суурь үеийн нөлөө, үйлдвэрлэгчийн үнийн өсөлт зэрэг олон асуудлаас шалтгаалан дэлхийн инфляц мэдэгдэхүйц өссөөр байна. Мексикийн төв банк энэ оны 8 дугаар сарын 12-ны өдрийн хурлаар инфляцын дарамтыг бууруулахын тулд бодлогын хүүгээ 0.25 нэгж хувиар өсгөж 4.5 хувьд хүргэжээ. Бодлогын шийдвэрт дараах хүчин зүйлс голлон нөлөөллөө.

- Тус улсын 7 дугаар сарын инфляцын түвшин өмнөх 4 сарын хамгийн бага буюу 5.81 хувьд хүрсэн хэдий ч төсөөллөөс өндөр бөгөөд төв банкны инфляцын зорилт ($3\pm1\%$)-оос давсан үзүүлэлт юм. Тухайлбал, нийлүүлэлтийн сүлжээний доголдолтой холбоотой хүнсний инфляц нэмэгдэж, үйлчилгээний салбарын үнийн өсөлттэй холбоотой суурь инфляц өсч байна.

Эх сурвалж: Төв банкуудын цахим хуудас

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ. ДОЛЛАРААР, 23/IX ӨДРИЙН БАЙДЛААР)





© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2021 №23

КОВИД–19 ХАЛДВАРЫН ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ОЛОН УЛС ДАХЬ ТӨСВИЙН БОДЛОГО

Жамбалдоржийн ЭНХБАЯР*

1. КОВИД–19 ХАЛДВАРЫН ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ТӨСВИЙН ЗОХИСТОЙ БОДЛОГО

Цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямралын үед төрөөс иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, ядуурал, тэгш бус байдлаас сэргийлэх, ажлын байрыг хадгалах, бүтээмж өндөртэй дижитал салбар руу шилжих, ажиллагчдын ур чадварыг нэмэгдүүлэх, татварын бодлогоор дамжуулан эмзэг бүлгийн санхүүгийн дарамтыг хөнгөлөх, хөл хорио, цар тахлын улмаас орлого нэмэгдсэн салбараас санхүүгийн эх үүсвэр цуглуулах болон бусад олон сорилттой тулгарч байна. Эдгээр сорилтыг амжилттай даван туулахын тулд төсвийн стратеги уян хатан байж, цар тахлын дараах гурван үе шат бүрт хэрэгжүүлэх арга хэмжээ хоорондоо харилцан адилгүй байна:

1. Вирусын тархалтаас сэргийлж хөл хорио тогтоосон үе;
2. Вирусын тархалтыг хумиж, эдийн засгийг хэсэгчлэн нээх үе;

3. Дархлаажуулалт ба эдийн засгийн сэргэлтийн үе.

Вирусын тархалт болон хөл хорионы дэглэмийн үед Засгийн газар иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, яаралтай тусламж хүргэх болон цар тахалд хамгийн хүндээр нэрвэгдсэн өрх, бизнесийн салбарыг хамгаалах чиглэлд ажиллах нь зүйтэй гэж ОУВС үзэж байна. Энэ хүрээнд ажлын байрыг хадгалах татаас, ажилгүйдлийн тэтгэмж олгох, татварын хөнгөлөлт үзүүлэх, аж ахуй нэгжүүдэд тэсч үлдэхэд нь туслах зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох, зээлийн баталгаа гаргах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Засгийн газраас хэрэгжүүлэх эдгээр төсвийн арга хэмжээ нь төв банк болон бусад зохицуулагч байгууллагын арга хэмжээтэй уялдаатай байх ёстой. Эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ болон Засгийн газрын дэмжлэгийн үр дүнд хямралын сөрөг нөлөөг зөөлрүүлэх, эдийн засгийн сэргэлтийн түргэсгэх юм.

* Монголбанкны Мөнгөний бодлогын газрын эдийн засагч.

Цахим шуудан: bayar.j@mongolbank.mn

Энэхүү судалгааны өгүүллийг бичихэд зөвлөсөн Б.Баярдаваа, Б.Түмэнцэнгэл болон Д.Болдбаатар нарт талархал илэрхийлье. Энд дурдагдах аливаа санал, дүгнэлт нь олон улсын санхүүгийн байгууллага, судлаач, шинжээчдийн зөвлөмж, улс орнуудын Засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээний эмхэтгэл бөгөөд Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Эдийн засгийг хэсэгчлэн нээх үе: Засгийн газраас хэрэгжүүлж буй дэмжлэгийг огцом зогсоох нь ядуурал, тэгш бус байдлыг нэмэгдүүлж хямралыг сунжруулах эрсдэлтэй билээ. Мөн өрхийн орлого тасалдан эрэлт хумигдаж, нийлүүлэлт удааширсан энэ үед эдийн засаг богино хугацаанд сэргэх эсэх нь эргэлзээтэй. Тиймээс Засгийн газраас хэрэгжүүлж буй халамж, тэтгэмжийг хэвээр үргэлжлүүлж, эдийн засгийн сэргэлтэд чиглэсэн бусад арга хэмжээг аажим эхлүүлэх шаардлагатай юм.

Төсвийн орон зай бага орны хувьд нэн тэргүүнд халдвар хамгааллын дэглэмийг сахисан эрсдэл багатай ажлын байрыг бий болгох, ажиллагчдад шинэ, бүтээмж өндөртэй салбарт ажилд орох боломжийг нээх, цар тахлын нөлөөнд автсан ч **цаашид оршин тогтнох чадамжтай бизнесийг дэмжих** бодлого баримтлах нь зүйтэй. Энэ хүрээнд ажлын байрыг хадгалахтай холбоотой татаасыг хумиж, ажилгүй иргэдийг онлайнаар сургалтад хамруулах зэрэг арга хэмжээ хэрэгжүүлэх боломжтой.

Мөн төсвийн орлого нэмэгдүүлэх зорилгоор татварын зохицуулалт хийх боломжтой. Тухайлбал, шаталсан татвар нэвтрүүлэх, татварын реформ хийх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх юм. Шаталсан татвар нэвтрүүлснээр цар тахлын нөлөөнд бага өртсөн, эсвэл орлого нэмэгдсэн салбараас эх үүсвэр татаж эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг санхүүжүүлэх боломж бүрдэнэ.

Дархлаажуулалт ба эдийн засгийн сэргэлтийн үед шилжихэд эдийн засаг дахь төрийн оролцоог сулруулж, хувийн болон төрийн секторын өрийн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ хүртээмжтэй, "ногоон" сэргэлтийг бий болгохыг зөвлөж байна. Төсвийн зохистой бодлогын сонголт нь тухайн улсын санхүүгийн чадамж, өрийн түвшин, хямралын гүнзгийрэлтээс хамааран харилцан адилгүй байх юм. Тухайлбал, төсвийн орон зай багатай орны хувьд төсвийн алдагдлыг даруй зогсоохгүй бол өрийн болон хүүний дарамт нэмэгдэж, эдийн засгийн сэргэлтийг хазаарлах аюултай [3].

Хямралын дараа эдийн засгийг ногоон, дижитал шилжилтэд суурилж сэргээх

Европын холбооны улсууд цар тахлын үед ногоон, дижитал шилжилтэд суурилсан сектор руу чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар дамжуулан эдийн засгийн тогтвортой, уян хатан сэргэлт бий болгохыг зорьж байна. Хямралын үед ногоон, дижитал салбарт төсвийн хөрөнгө оруулалтыг чиглүүлэн дэд бүтцийг хөгжүүлснээр тус салбарт бусад төрлийн хөрөнгө оруулалт нэмэгдэх суурийг тавих юм. Ингэснээр эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг зөв зүгт чиглүүлж, капитал, ажиллах хүч хамгийн бүтээмж өндөртэй салбар руу шилжих боломж бүрдэнэ.

Цар тахлын нөлөөгөөр дижитал хэлбэрт аль хэдийн шилжсэн онлайн худалдаа, медиа, банкны салбарууд хамгийн их давуу талыг олж авах бөгөөд, эдийн засгийн бүтцэд "шинэчлэл"¹ хийгдэж буй энэ үед бусад салбарууд ч мэдээлэл, харилцаа холбооны технологид чиглэсэн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх шаардлага үүсэх юм [1].

Өрийн түвшин өндөртэй, төсвийн хязгаарлагдмал байдалд байгаа улсуудад тулгарах хүндрэл

Улс орнуудын хувьд дунд хугацааны эдийн засгийн өсөлтийн төлөв цар тахлын өмнөх үеэс бага төлөвт шилжсэнээр татварын суурь хумигдаж, нөгөө талаас зардал тэлэн улсын өр нэмэгдэж байна. Цар тахлаас өмнө өрийн хэмжээ өндөр байсан улсуудын хувьд өрийн тогтвортой байдлыг хангахад бэрхшээл тулгарах бөгөөд Засгийн газрын зээлийн хүүний төлбөрийн төсвийн орлогод эзлэх хувь нэмэгдсэнээр төсвийн бодлогоор эдийн засгийн сэргэлтийг дэмжих, ядуурал, тэгш бус байдлыг бууруулах боломжийг хумих эрсдэлтэй байна. Цар тахлын үеийн хөл хорионы нөлөө хамгийн хүндээр нөлөөлөх бүлэг нь бага орлоготой, албан бус секторт ажил эрхлэгч, үйлчилгээний салбарт ажиллагчид, эмэгтэйчүүд болон ирээдүйн ажиллах хүчийг бүрдүүлэх хүүхдүүд байх юм.

Ядуурал, тэгш бус байдал, хүмүүн капиталын хомсдол

Өмнөх хямралуудтай харьцуулахад хөл хорионы дэглэмийн үед зайнаас ажиллах боломжгүй

¹ "Great re-set"

салбарын ажиллагсад, албан бус секторт ажиллагч, цагаач иргэд, бага цалинтай, ажилд шинээр орсон залуучууд орлогын хувьд хамгийн сөрөг нөлөөллийг үүрэх бөгөөд төрөөс олгох халамж, дэмжлэгт хамрагдах боломж бага юм. Ингэснээр нийгмийн хамгийн эмзэг бүлэгт хямралын сөрөг нөлөө хүндээр тусч, ядуурал, нийгмийн тэгш бус байдлыг нэмэгдүүлэх шалтгаан болох эрсдэлтэй. Түүнчлэн, цар тахлын үед боловсролын байгууллагыг удаан хугацаагаар хаах тусам хүүхдүүдийн боловсрол олж авах боломж буурах, тэдний асран хамгаалагч, ялангуяа ээжүүдийн хувьд ажил эрхлэх боломж хумигддаг байна. Энэ нь богино болон урт хугацаанд хүний нөөцийн чадавхийг бууруулах, орлогын тэгш бус байдлыг нэмэгдүүлэх нөлөөтэй юм [6].

Хямралын дараах татварын бодлого

Хямралын үед улс орнууд эрэлт, нийлүүлэлтийг дэмжих зорилгоор зарим төрлийн татвараас хөнгөлөх, чөлөөлөх зэрэг богино хугацааны арга хэмжээ хэрэгжүүлж байна. ОУВС-гаас хямралын дараагаар эдийн засгийн тогтвортой, "ногоон" өсөлтийг дэмжих, орлогын тэгш байдлыг нэмэгдүүлэх, татварын суурийг өргөтгөх чиглэлд татварын бодлогоо сайжруулах хэд хэдэн зөвлөмж гаргажээ. Үүнээс, хөгжиж буй орнуудад өгсөн зөвлөмжийг нэгтгэн тайлбарлая.

Орлогын тэгш байдлыг сайжруулахад прогрессив буюу шаталсан татвар чухал хүчин зүйл болно. Өөрөөр хэлбэл, аливаа татвар нь орлого багатай иргэдэд дарамт багатай байх ёстой. Татварын орлого нь орлогын татвар, хэрэглээний татвараас бүрдэнэ. Урт хугацааны эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөг нь харвал орлогын татвар нь хэрэглээний татвартай харьцуулахад өсөлтийг сааруулах нөлөө нь өндөр байдаг. Эсрэгээрээ, орлогын татварын нийгэм дэх орлогын тэгш байдлыг хангах тал дээр илүү нөлөөтэй байдаг байна.

- **Орлогын шаталсан татвар:** Цар тахлын үед орлого буурсан иргэдэд ирэх санхүүгийн дарамтыг бууруулах, нөгөө талаас, өндөр орлоготой, цар тахлын улмаас орлого өссөн цөөн салбар (*онлайн худалдаа, интернет, харилцаа холбоо г.м.*)-т ажиллагчдаас төвлөрөх орлогын дүнг нэмэгдүүлэх

боломж бүрдэнэ. Ингэхдээ татварын шатлалын хэмжээг оновчтой тогтоох нь чухал. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын хувьд татварын хамгийн өндөр шатлалд ногдох орлогын хэмжээ нь дундаж цалингаас 3 дахин өндөр байдаг байна.

- **Жижиг дунд үйлдвэрлэлд чиглэсэн татварын хөнгөлөлтөөс зайлсхийх:** Зарим оронд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор ААНОАТ-ын хувь хэмжээг бууруулах зэрэг хөнгөлөлт үзүүлдэг. Энэ төрлийн татварын хөнгөлөлт нь чинээлэг, олон тооны жижиг бизнес эзэмшигч бүлгийг илүүтэй дэмжих, мөн бизнес томорч хөгжих сонирхлыг бууруулах зэрэг сул талтай байдаг.

Хэрэглээний татвар нь орлогын татвартай харьцуулахад прогрессив шинж чанар бага байдаг. Гэвч хэрэглээний татвар төсвийн орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлэх² бөгөөд тэрхүү татварын орлогын зарцуулалт нь тэгш байдлыг дэмжиж байх нь чухал юм.

- **Нэмэгдсэн өртгийн албан татвар ноогдуулах доод хязгаар тогтоох:** Хөгжиж буй орнуудад нийгмийн хамгийн орлого багатай иргэд хоол хүнс, хэрэгцээт бараагаа жижиг дэлгүүр, худалдааны газраас худалдан авдаг тул тэдгээр худалдааны газруудын нэмэгдсэн өртгийн албан татварыг хөнгөлөх нь татварын прогрессив шинж чанартай нийцтэй юм.

- **Онлайн худалдаанд нэмэгдсэн өртгийн албан татвар ноогдуулах:** Цар тахалтай холбоотой энэ төрлийн татварын зохицуулалт хийх шаардлага улам нэмэгдэж байна. Хөл хорио тогтоосонтой холбоотойгоор орлого хамгийн ихээр нэмэгдсэн салбаруудын нэг болох онлайн худалдааны салбарт нэмэгдсэн өртгийн албан татвар ноогдуулснаар цар тахлын үед татварын орлогыг дэмжих, шаардлагатай зардлуудыг санхүүжүүлэх эх үүсвэр бүрдүүлнэ. Үүний тулд бодлого боловсруулагчдын зүгээс татварын зохицуулалтад шаардлагатай *дижитал дэд бүтцийн асуудлыг* шийдэх хэрэгтэй.

Онцгой албан татвар: Зарим орон татварын

² Монгол Улсын татварын орлогын 50 орчим хувийг хэрэглээний татвар бүрдүүлж байна.

орлогын суурийг тэлэх зорилгоор харилцаа, холбооны салбар, сошиал медиа талбар, онлайн худалдааны салбарт онцгой албан татвар ногдуулахаар зохицуулж байна [5].

2. УЛС ОРНУУДЫН ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ БОДЛОГО

Дэлхий нийтээр цар тахлын үед хэрэгжүүлж буй төсвийн нэмэлт арга хэмжээ 2020 онд \$14.0 их наяд хүрснээс \$7.8 их наяд нь төсвийн нэмэлт зардал, татварын хөнгөлөлт, 6.0 их наяд нь зээл, зээлийн баталгаа зэрэгт зарцуулагджээ. Төсвийн зардал нэмэгдэж, эдийн засгийн идэвхжил буурч орлого тасалдсан нөлөөгөөр төсвийн алдагдал хөгжингүй орнуудад –13.3 хувь, хөгжиж буй, дунд орлоготой орнуудад –10.3 хувь, бага орлоготой орнуудад –5.7 хувьд хүрчээ.

Үүнийг дагаад улс орнуудын Засгийн газрын өр дунджаар ДНБ-ий 98 хувьд хүрч, өмнөх оныхоос 14.1 нэгж хувиар нэмэгдлээ. Тухайлбал, Канад, Япон, АНУ, Итали, Испани зэрэг “Их 20” бүлгийн орнуудад өрийн хэмжээ хамгийн ихээр буюу ДНБ-ий 20-30 нэгж хувиар нэмэгджээ. Эдгээр оронд халдварын тархалт эрчимтэй байснаас шалтгаалж төсвийн зардал огцом нэмэгдсэнээс гадна бизнесийн эрхлэгчдийг дэмжихэд чиглэсэн бусад арга хэмжээ хурдтай хэрэгжүүлж байна.

ОУВС-гаас 193 орны сангийн болон мөнгөний бодлогын хариу үйлдэл, арга хэмжээг эмхэтгэснийг дараах гурван бүлэгт хуваан авч үзэж, хэрэгжүүлж буй бодлогын онцлогийг харьцууллаа. Үүнд:

- **Хөгжингүй улс орнууд (АЕ)** – улс орнуудын ОУВС-ын ангиллаар **хөгжсөн** гэх ангилалд багтаж буй голлох³ эдийн засаг;
- **Хөгжиж буй улс орнууд (EMDE)** – улс орнуудын ОУВС-ын ангиллаар **бүрэлдэж буй эдийн засаг ба хөгжиж буй улс** гэх ангилалд багтаж буй голлох эдийн засаг;
- **Түүхий эдийн экспортологч** – “Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн шинжилгээ” судалгаа [7]-нд тодорхойлсон түүхий эдийн экспортоос өндөр хамааралтай эдийн засаг

багтана.

Дээрх ангиллаар Хүснэгт 2-т 33 улс орныг авч үзэж, Ковид 19-ийн үеийн төсвийн бодлогын харьцуулалтыг хийлээ. Сонгогдсон бүх улсад коронавирусын тохиолдол бүртгэгдсэн, улсын хилээ хааж, карантин тогтоожээ.

Сонгосон 33 улсын хэрэгжүүлж буй арга хэмжээг дүгнэхэд, эхний ээлжинд эрүүл мэндийн зайлшгүй зардлыг санхүүжүүлэх, эмзэг бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн шилжүүлгийг нэмэгдүүлэх, цаашлаад хөрөнгө санхүүгийн боломжоос шалтгаалж цар тахлын улмаас хохирсон ажиллах хүч, ажил олгогчдыг дэмжих арга хэмжээ авчээ.

о Хөгжингүй орнууд дунджаар ДНБ-ий 11.3 хувьтай тэнцэх хэмжээгээр төсвийн зардлыг нэмэгдүүлснээс 1.6 нэгж хувь нь эрүүл мэндийн салбарт, 9.7 нэгж хувь нь ажилгүйдлийн тэтгэмж, нийгмийн халамжийн шилжүүлэг, ажлын байрыг хадгалах татаас болон бусад зориулалтаар зарцуулжээ. Хөгжиж буй орнуудын дундажтай харьцуулахад эрүүл мэндийн бус салбарын нэмэлт зардал нь 7.2 нэгж хувиар өндөр байна.

о Түүхий эдийн экспортоос өндөр хамаарал бүхий ангилалд багтсан орнуудын хувьд төсвийн нэмэлт зардлын хэмжээ ДНБ-ий 4.5 хувьтай тэнцэж байгаа бөгөөд хамгийн их нэмэлт зардал гаргасан оронд Чили, Перу зэрэг улс багтаж байна.

о Хөгжингүй орнууд төрийн өмчит банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, цар тахлын улмаас хүндрэлд орсон салбарын бизнес эрхлэгчдэд зээл олгох, зээлийн баталгаа гаргах зэргээр хөрвөх чадварыг дэмжих чиглэлд тэргүүлж байна. Хөрвөх чадварыг дэмжих арга хэмжээ нь нийлбэр дүнгээр хөгжиж буй орнуудад ДНБ-ий 2.4 хувь, түүхий эдийн экспортоос өндөр хамаарал бүхий орнуудад 3.2 хувь, хөгжингүй орнуудад 15.6 хувьтай тэнцэж байна. Үүнээс, хөгжингүй орнуудад зээлийн баталгаа ДНБ-ий 11.8 хувьтай тэнцүү байна.

³ ОУВС-ийн тайланд нэрийг нь тусгайлан бичдэг улсуудыг голлох гэсэн ангилалд орууллаа.

Монголбанк 2021 оны 8 дугаар сард 1.9 тн үнэт металл худалдан авч, оны эхнээс өссөн дүнгээр нийт 12.9 тн үнэт металл худалдан аваад байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1.8 тн-оор буурсан үзүүлэлт юм.

2021 оны 8 дугаар сарын хувьд Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 109.5 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 162.1 кг үнэт металл худалдан авсан.

Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж ханш 2021 оны 8 дугаар сард 163,323.50 төгрөг байлаа.

График 1. 2018-2021 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын сарын мэдээ (кг)






График 2. 1990-2021 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын хэмжээ (тонн)



График 2. 2021 оны 8 дугаар сард Монголбанкны алт худалдан авсан үнэ (төгрөг/грамм)





МОНГОЛ УЛСЫН БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН САНХҮҮГИЙН МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд дараагийн шатны арга хэмжээ болох “Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны төлөвлөгөө”-г боловсрууллаа. Төлөвлөгөө нь санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хувийн болон бизнесийн санхүүгээ зөв удирдахад дэмжлэг болох ач холбогдолтой бөгөөд Монголбанк, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам чиглүүлж, Санхүүгийн зохицуулах хороо, Жижиг, дунд үйлдвэрийн газар, Нийслэлийн жижиг дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төв, Насан туршийн боловсролын үндэсний төв, Зээлийн батлан даалтын сан, Хадгаламжийн

даатгалын корпораци, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон Монголын банкны холбоо гэсэн оролцогч талуудыг багтаасан ажлын хэсгийн оролцоотой хэрэгжүүлнэ.

Дунд хугацааны буюу 5 жилийн төлөвлөгөөний зорилго нь бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны давхардлыг арилгаж харилцан уялдааг хангах, үр дүнг нэмэгдүүлэх замаар эдийн засаг болон санхүүгийн салбарын тогтвортой байдал, хөгжилд хувь нэмэр оруулах юм. Тус баримт бичгийг боловсруулах эхний үе шатанд Монголбанкнаас БЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийн өнөөгийн түвшинг тодорхойлох зорилгоор 2020

онд 300 гаруй БЖДҮ эрхлэгчдээс түүвэр судалгааг авсан. Судалгааны үр дүнгээс харахад Монгол Улсад БЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хийх ажлууд нэн шаардлагатайг бизнес эрхлэгчид өөрсдөө дүгнэсэн байна. Цаашлаад дараах дүгнэлтийг гаргасан. Үүнд:

- БЖДҮ эрхлэгчдэд зориулсан сургалтын материал багагүй байгаа боловч талуудын уялдаа холбоо, хамтын ажиллагаа сул тул сургалт, мэдээллийн давхцалтай;
- Нэгдсэн зохицуулалт буюу координаци үгүйлэгдэж байгаа;
- БЖДҮ эрхлэгчдэд зориулсан сургалтууд нь хэт онолын шинжтэй, практик уялдаа шаардлагатай;

- БЖДҮ эрхлэгчид чанартай сургалтыг төлбөртэй байсан ч хамаагүй авах хүсэлтэй.

Нөгөөтээгүүр, Шпаркассэ банкны олон улсын сан болон IPC-ийн мэргэжилтнүүдээс бүрдсэн зөвлөх багийн 2020 онд гүйцэтгэсэн судалгаанаас харахад БЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр хэд хэдэн байгууллага төслүүдийг хэрэгжүүлсэн буюу хэрэгжүүлж буй боловч тэдгээр нь харилцан уялдаагүй явж иржээ.

Улс орнуудын хувьд иргэдийнхээ санхүүгийн боловсролын асуудалд анхааран, улам бүр ач холбогдол өгч бодлогын хэмжээнд авч үзэж байгаа бөгөөд 2013 онд хөгжсөн болон хөгжиж буй 45 орон олон нийтийн санхүүгийн боловсролын хөтөлбөр, бодлогыг боловсруулан хэрэгжүүлж байсан бол 2021 оны 7 сарын байдлаар 125 орон болжээ. БЖДҮҮ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх асуудлыг ихэнх улс орнуудын хувьд санхүүгийн боловсролын нэгдсэн бодлогын баримт бичигтээ тусгасан байдаг. Баримт бичгийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь тухайн орны санхүүгийн зах зээлийн хөгжлийн түвшин, бизнес эрхлэгчдийн хэрэгцээ шаардлага зэргээс хамаардаг.

Тиймээс Монгол Улсын эдийн засгийн оролцогчид, ялангуяа хувиараа бизнес эрхлэгч, БЖДҮҮ эрхлэгчдийн санхүүгийн

мэдлэгийг дээшлүүлэх нь хувийн бизнес болон санхүүгийн салбарыг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй юм.

Иймд хэрэгжүүлэгч болон оролцогч талуудтай хэлэлцсэний үндсэн дараах 4 тэргүүлэх чиглэлд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тогтлоо. Үүнд:

- Хувиараа бизнес эрхлэгч;
- Бичил, жижиг (бичил шинжтэй) үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч;
- Жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч;
- Дунд үйлдвэрлэл эрхлэгч.

Манай орны эдийн засаг уул уурхайн салбарын экспортоос ихээхэн хамааралтай хэвээр байгаа хэдий ч нөгөө талаас БЖДҮҮ-ийн салбар нь дотоодын нийт бүтээгдэхүүний -ийг бүтээж, нийт ажлын байрны 50 гаруй хувийг бүрдүүлж байна. Энэхүү төлөвлөгөө нь амжилттай хэрэгжсэнээр эдийн засгийг солонгоруулахад дэмжлэг болохын зэрэгцээ байгалийн баялгийн экспортоос хамаарах хамаарлыг багасгах, санхүүгийн салбарыг бэхжүүлэх ач холбогдолтой.

МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ЯТГАХ ТУСАМ
НЯГҒАЛ!

**ЗАЛИЛАГЧИД
БОЛОМЖ БҮҮ ОЛГО**

Та нууц үгээ санаандгүй хэн нэгэнд
мэдэгдсэн, эсвэл хангалттай сайн
нууцлалтай биш гэж үзэж байвал нууц
үгээ тэр дор нь сольж, цахим залиланд
өртөхөөс сэргийлээрэй.



ЯТГАХ ТУСАМ
НЯГҒАЛ!

